



YOUR
RESEARCH
PARTNER



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ИРГЭДИЙН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЭЦСИЙН ХУВИЛБАР



2021.07.08

Захиалагч: Харилцаа Холбооны Зохицуулах Хороо

Гүйцэтгэгч: "Эм Эм Си Жи" ХХК



ESOMAR^{'21}
corporate



Гэрээний дугаар №: ХХЗХ/202112034

Хүлээн авсан:

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын дарга, З.ЭРДЭНЭЧУЛУУН

/...../ /гарын үсэг, тамга тэмдэг/

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Интернэтэд суурилсан үйлчилгээ, технологийн хэлтсийн дарга, Т.БАТБОЛД

/...../ /гарын үсэг/

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Хамтын ажиллагаа, харилцагчийн хэлтсийн дарга, Б.МЯГМАРНАРАН

/...../ /гарын үсэг/

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Цахим орчны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, Г.ЭНХМАА /...../ /гарын үсэг/

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Олон нийтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Д.НАРАНСОЛОНГО /...../ /гарын үсэг/

Хүлээлгэн өгсөн:

Эм Эм Си Жи ХХК, Гүйцэтгэх захирал

Д.БУМ-ЭРДЭНЭ /...../ /гарын үсэг, тамга тэмдэг/

Эм Эм Си Жи ХХК, Нийгмийн судалгааны менежер

Л.ПҮРЭВЦЭНГЭЛ /...../ /гарын үсэг/

ИРГЭДИЙН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ СУУРЬ СУДАЛГАА

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны санхүүжилтээр “Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа”-г үндэсний судалгааны Эм Эм Си Жи ХХК үндэсний хэмжээнд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг ЭЗОМАР судлаачийн ёс зүйн код болон Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгааны ISO 20252:2019 олон улсын стандартын дагуу Монгол Улсын 18-64 насны иргэдийг төлөөлүүлэн нийслэл Улаанбаатар хотын 9 дүүрэг, 6 аймгийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд 1035 иргэнийг утсаар судалгаанд хамруулж, энэхүү тайланг бэлтгэсэн болно.

Энд дурдагдаж буй судалгааны үр дүн нь судалгаанд оролцогчдын мэдлэг, хандлага, санал бодол дээр шууд үндэслэгдсэн гэдгийг анхаарна уу.



ТАНИЛЦУУЛГА

1

**СУДАЛГААНЫ АРГА,
АРГАЧЛАЛ**

2

ХУРААНГУЙ ҮР ДҮН

3

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ,
ЗӨВЛӨМЖ**

ХАВСРАЛТ

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
1. ТАНИЛЦУУЛГА	8
2. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ.....	11
2.1 Аргачлал, аргагүйн үндэслэл.....	12
2.2 Судалгааны хамрах хүрээ	13
2.3 Судалгааны асуулгыг боловсруулсан байдал	14
2.4 Судалгааны багийн зохион байгуулалт	16
2.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт	17
2.6 Судалгааны мэдээллийн чанарын хяналт.....	19
2.7 Судалгааны анализ, дүн шинжилгээ	21
3. ХУРААНГУЙ ҮР ДҮН	23
4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	27
4.1 Интернэтийн хэрэглээ, бусад улстай харьцуулсан байдлаар.....	27
4.2 Интернэтийн зохистой хэрэглээний талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага.....	34
4.3 Судалгаанд хамрагдсан иргэдийн интернэт хэрэглээ	45
4.4 Иргэдийн өдөр тутмын интернэтийн хэрэглээ	48
4.5 Иргэдийн мэдлэг, хандлага, туршлага хоорондын хамаарал	56
4.6 Иргэдийн цахим гэмт хэрэгт өртсөн байдал	57
4.7 Иргэдийн мэдээ, мэдээлэл авсан байдал ба хүлээн авахыг хүсэж буй хэрэгсэл, хэлбэр	61
4.8 Цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, зохион байгуулалт	63
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	67
ХАВСРАЛТ.....	70
Иргэдийн тоон судалгааны асуулга	70
Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нарын гүнзгийрүүлсэн ярилцлагын удирдамж.....	81



I ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

САТИ	Computer-Assisted Telephone Interview
САВИ	Computer-Assisted Web Interview
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ИҮҮ	Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч
КАП	Мэдлэг, хандлага, туршлагын судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФБ	Фэйсбүүк
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар

I ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: Үүрэн холбооны дата ачаалал, оноор, терабайт	34
График 2: ХХЗХ-ны зохицуулалтын талаар мэддэг эсэх, насны бүлгээр	36
График 3: Public/private тохиргооны талаарх иргэдийн мэдлэг, насны бүлгээр	36
График 4: Цахим орчны зохисгүй хэрэглээнээс үүдэх эрүүл мэндийн эрсдэлүүдийн тухай ойлголт	37
График 5: Эцэг эхчүүд цахим орчинд хүүхдүүддээ хяналт тавьж чаддаг эсэх, насны бүлгээр	38
График 6: Эцэг эхчүүд хүүхдүүдээсээ илүү сошиал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал эсэх, байршлаар.....	39
График 7: Иргэд интернэт орчинд соёлтой байж чаддаггүй гэдэгтэй санал нийлэх хувь, насны бүлгээр.....	40
График 8: Цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд хийж болох үйлдлүүд	41
График 9: Хувийн мэдээллээ алдсанаар үүсэж болох эрсдэлийн талаарх иргэдийн ойлголт..	42
График 10: Интернэтэд орохдоо ашигладаг төхөөрөмж	45
График 11: Интернэтэд холбогддог сүлжээний төрөл	45
График 12: Интернэт ашиглаж буй зорилго.....	46
График 13: Нэг өдөрт интернэт хэрэглэж байгаа дундаж хугацаа, минутаар	47
График 14: Нэг өдөрт интернэтэд зарцуулж буй хугацаа, минутаар	47
График 15: Өөрийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг байдал, нас хүйсээр.....	50
График 16: Сошиал хаяг болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп-уудын (банкны апп зэрэг) нууц үг өөр өөр байдаг иргэдийн хувь, нас хүйсээр	50
График 17: Төхөөрөмжийн программаа шинэчилдэг иргэдийн хувь	51
График 18: Интернэт орчинд байгаа мэдээлэл хуурамч эсэхийг болон мэдээллийн эх үүсвэрийг шалгаж үздэг иргэдийн хувь, нас, хүйсээр.....	51
График 19: Цахим хаягийн нууц үгнүүдээ 6 сар тутам сольдог иргэдийн хувь, нас хүйсээр...	52
График 20: Гар утас, бусад төхөөрөмжийн хэт их хэрэглээнээс болоод нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал тулгардаг иргэдийн хувь, нас хүйсээр.....	53
График 21: Өглөө босоод шууд сошиал хаягаа хамгийн түрүүнд шалгадаг иргэдийн хувь.....	53
График 22: Кино, драма зэрэг зохиогчийн эрхтэй контентыг интернэтээр үнэгүй үздэг	54
График 23: Хоол идэж байхдаа интернэт ашигладаг иргэдийн хувь	54
График 24: Төлбөртэй программ, тоглоомыг интернэтээс үнэгүй татаж авч байсан, нас хүйсээр.....	55
График 25: Цахим гэмт хэрэгт өөрөө болон ойр дотны хэн нэг нь өртсөн байдал (Эх олонлогт тархаасан байдлаар).....	57
График 26: Цахим гэмт хэрэгт өөрөө болон ойр дотны хэн нэгэн өртсөн байдал, насны бүлгээр.....	58
График 27: Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ өөрөө болон ойр дотны хэн нэгний хийсэн үйлдэл	60
График 28: Цахим орчны зохистой хэрэглээ, аюулгүй байдлын талаар мэдээ мэдээлэл авч байсан эсэх.....	61

ІЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Үйл ажиллагааны ерөнхий дараалал.....	9
Зураг 2: Мэдээлэл цуглуулалтын үе шатууд.....	18
Зураг 3: Мэдээлэл цуглуулалтын явц.....	18
Зураг 4: Утсаар судалгаа авах төвийн автомат программ хангамж.....	19
Зураг 5: Хяналтын ажилтны бөглөсөн алдааны протоколын харагдах байдал	20
Зураг 6: SPSS программ дээр судалгааны дата харагдах байдал	21
Зураг 7: Зургаа, түүнээс дээш настай хүн амд интернэт хэрэглэгчдийн эхлэх хувь, хот, хөдөөгөөр, 2020 он	30
Зураг 8: Зургаа, түүнээс дээш насны хүн амын интернэтийн хэрэглээ, нас, хүйсийн суварга	31
Зураг 9: Хүн амын тоо, насны бүлэг, хувийн жингээр, 1963-2045 он	32
Зураг 10. Гар утас хэрэглэдэг хүн ам, насны бүлгээр, хувиар	33
Зураг 11: Мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг	35
Зураг 12: Технологийн тохиргоонуудыг мэддэг байдал	35
Зураг 13: Интернэтийн зохистой хэрэглээтэй холбоотой иргэдийн хандлага	38
Зураг 14: Интернэтийн хэрэглээний талаарх сөрөг хандлага.....	39
Зураг 15: Тоон гарын үсгийн талаарх иргэдийн ойлголт	44
Зураг 16: Интернэтийн орчин дахь хэрэглээ	49
Зураг 17: Цахим гэмт хэрэгт өрвөл хандах байгууллага	59
Зураг 18: Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ өөрөө болон ойр дотны хэн нэгний хийсэн үйлдэл	59
Зураг 19: Таалагдах контентын төрөл, насны бүлгээр	65


І ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Түүврийн хэмжээ, аймаг дүүргээр	14
Хүснэгт 2: Судалгааны баг бүрэлдэхүүн.....	16
Хүснэгт 3: Тоон судалгааны мэдээлэлд хяналт хийсэн хэлбэр	20
Хүснэгт 4: Судалгааны хураангуй үр дүнгийн хүснэгт	23
Хүснэгт 5: Гар утас, интернэтийн хэрэглээ, дэлхийн дундажтай харьцуулсан байдлаар.....	28
Хүснэгт 6: Монгол Улсын интернэт хэрэглээ, зарим улс оронтой харьцуулсан байдлаар.....	28
Хүснэгт 7: Өрхийн тоо, өрхийн интернэт хэрэглэгчийн тооны харьцуулалт, 2020 он.....	31
Хүснэгт 8: Мэдээ мэдээлэл авахыг хүсэж буй мэдээллийн хэрэгсэл, байршил, насны бүлгээр	61
Хүснэгт 9: Мэдээ мэдээлэл авахыг хүсэж буй хэлбэр, хот хөдөөгөөр, насны бүлгээр.....	62
Хүснэгт 10: Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө.....	63
Хүснэгт 11: Иргэдэд хүргэх мэдээлэл харилцааны агуулга, хэлбэр, зорилтот бүлгээр	64



ТАНИЛЦУУЛГА

1




1. ТАНИЛЦУУЛГА

Харилцаа холбооны зохицуулах хороотой хийсэн №ХХЗХ/202112034 тоот гэрээний дагуу “Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа”-г “Эм Эм Си Жи” үндэсний судалгааны компани зохион байгуулж байна.

Тус судалгааны ажил нь Монгол Улсын 18-аас дээш насны нийт хүн амын интернэтийн зохистой хэрэглээ болон цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт, учирч болох эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж, мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд авах авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах; Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг бий болгоход төр засгийн зүгээс цаашид баримтлах бодлого шийдвэрийн талаар дүгнэлт, зөвлөмжийг судалгаанаас гарсан тоон мэдээлэлд үндэслэн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас саналыг авч боловсруулах зорилготой.

Судалгааны ерөнхий үйл ажиллагааны дарааллыг Зураг.1-т дүрслэв. Суурь судалгаа нь үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Зураг 1: Үйл ажиллагааны ерөнхий дараалал




Судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу судалгааны баг суурь судалгааны асуулга хэрэглэгдэхүүнийг боловсруулж, захиалагчаас санал аван эцэслэн баталгаажуулж, судлаачдын сургалтыг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулан, судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 6 дугаар сарын 18-ны өдрийн хооронд утсаар судалгаа авах төв (CATI)-өөр дамжуулан хийж гүйцэтгэлээ.



СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

2



I2. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

“Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа” нь дараах үндсэн 2 зорилготой.

1. Монгол Улсын 18-аас дээш насны нийт хүн амын интернэтийн зохистой хэрэглээ болон цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт, учирч болох эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж, мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд авах авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.
2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг бий болгоход төр засгийн зүгээс цаашид баримтлах бодлого шийдвэрийн талаар дүгнэлт, зөвлөмжийг судалгаанаас гарсан тоон мэдээлэлд үндэслэн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас саналыг авч боловсруулах.

Суурь судалгааны хүрээнд үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай 18-64 насны 1035 иргэдийг санамсаргүйгээр түүвэрлэн, утсаар тоон судалгаа зохион байгуулж, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөлтэй онлайн гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Монгол Улсын 18-64 насны нийт хүн амыг төлөөлөх чадвартай иргэдийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон Дорнод аймаг, Өвөрхангай аймаг, Ховд аймаг, Төв аймгийн төв болон хүн ам ихтэй сумдыг түүвэрт сонгон авсан.

Тус суурь судалгаагаар иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх ойлголт мэдлэгийг тодруулж, эерэг сөрөг хандлагыг тодорхойлон, өдөр тутмын дадал хэвшил болгосон эсэх, цахим гэмт хэрэгт өртөж байсан эсэх зэргийг тодруулсан. Судалгааны хүрээнд дараах үндсэн асуултуудад хариулах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Интернэтийн зохистой хэрэглээний талаарх иргэд хэр зэрэг мэдлэг, ойлголттой байна?
- Интернэтийн зохистой хэрэглээний талаар иргэдийн хэдэн хувь нь зөв эсвэл буруу хандлагатай байна?
- Иргэд ер нь интернэтийг зохистой хэрэглэж байна уу?
- Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээний түвшин ийм байгаад мэдлэг бага байгаа нь нөлөөлөөд байна уу?
- Эсвэл буруу хандлага нөлөөлөөд байна уу?
- Эсвэл иргэд интернэтийн зохистой хэрэглээний талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй, зөв хандлагатай боловч дадал зуршил болгож чадаагүй байна уу?
- Мэдлэг бага байвал ямар ямар мэдлэгийг иргэдэд өгөх хэрэгтэй вэ?
- Хандлага буруу байвал ямар хандлагыг нь өөрчлөх хэрэгтэй вэ?
- Дадал зуршил суугаагүй байвал интернэтийн зохистой хэрэглээг зуршил болгох мессежийг өгөх хэрэгтэй юу?
- Мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаар иргэд юу юу мэддэг вэ?
- Мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаар иргэдийн хандлага ямар байна вэ?

- Тэд мэдээллийн технологийн аюулгүй байдлаа хангаж чадаж байна уу?
- Чадахгүй байгаа бол мэдлэг, мэдээлэл дутуу болохоор уу?
- Эсвэл мэдлэг, мэдээлэл сайн боловч буруу хандлагатай байна уу?
- Мэдлэг мэдээлэл сайн, зөв хандлагатай боловч өөрийн дадал зуршил болгож чадаагүй байна уу?
- Иргэдэд мэдлэг мэдээлэл олгох хэрэгтэй юу?
- Эсвэл иргэдийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй юу?
- Мэдээллийн технологийн аюулгүй байдлаа хангадаг дадал зуршил суулгах хэрэгтэй юу?

Өөрөөр хэлбэл иргэдийн мэдлэг, хандлага, туршлагын түвшнийг тоогоор илэрхийлэн тогтоож, иргэдэд мэдээлэл сурталчилгааны ажил хийхдээ чухам юун дээр төвлөрөх хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлно. Мөн ямар хүн ам зүйн бүлэг нь юугаараа ялгаатай байна, хэнд нь хэрхэн ямар мэдээллийг ямар сувгаар, ямар хэлбэрээр хүргэх шаардлагатай байна вэ зэргийг тодорхойлно.

2.1 Аргачлал, аргазүйн үндэслэл

Суурь судалгааг зохион байгуулахдаа олон улсад түгээмэл ашиглагддаг **КАП (KNOWLEDGE, ATTITUDE AND PRACTICE) – МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ТУРШЛАГА АРГАЗҮЙГ** үндэслэв. Энэхүү аргазүй нь тодорхой сэдвийн талаарх зорилтот бүлгийн хүмүүсийн юу мэдэж байгааг (Мэдлэг - Knowledge), юу бодож байгааг (Хандлага - Attitude) болон юу хийдэг болохыг (Туршлага - Practice) стандарт хэлбэрийн бүтэцчилэгдсэн тоон болон чанарын асуултуудаар тодорхойлдог¹.

КАП судалгааны аргачлалыг тодорхой сэдвийн талаар хүмүүсийн зан үйлд нөлөөлөх аян, арга хэмжээ, хөтөлбөрийг² зохион байгуулахын өмнө нь суурь түвшнийг тодорхойлох болон дараа нь үр дүнг хэмжих зорилгоор хэрэглэдэг. КАП судалгааны үр дүн нь дараах зорилгуудаар ашиглагдах боломжтой.

- Аян, арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвлөхөд шаардлагатай мэдлэгийн ялгаа, соёлын онцлог хандлага, зан үйлийн өөр өөр хэлбэрүүдийг тодорхойлох;
- Тодорхой зан үйлд нөлөөлдөг тодорхой мэдлэг, хандлага, хүчин зүйлсийг тодорхойлох, энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх;
- Аян, арга хэмжээний дагуу өөрчлөгдөж болох суурь түвшнийг тодорхойлох, зорилтот түвшнийг төлөвлөх, өөрчлөлт үр дүнг хэмжих;
- Аян, арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрүүд, мэдээлэл түгээх сувгуудыг тодорхойлох, үнэлэх;
- Аян, арга хэмжээ, хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх.

¹ ДЭМБ, КАП аргачлалын үндэс, https://www.who.int/cholera/vaccines/КАП_protocol.pdf

² Компанит ажил, зан үйлд нөлөөлөх зорилготой аян, арга хэмжээ, нөлөөллийн ажил – behavior change communication (BCC)

Судалгааны бүх үе шатанд ёс зүй, мэргэжлийн чиг баримжаатай байж, ЭЗОМАР³ судлаачийн ёс зүйн код, Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгааны ISO 20252:2019⁴ олон улсын стандартыг мөрдлөг болгон ажиллалаа. Уг стандартын хавсралтад заасан:

- Хавсралт А (норматив) “Панелийг багтаасан түүвэрлэлт”
- Хавсралт В (норматив) “Мэдээлэл цуглуулалт”
- Хавсралт F (норматив) “Өгөгдлийн удирдлага ба боловсруулалт” гэсэн хэсгүүдийг удиртгал болгон баримталж суурь судалгааг хийж гүйцэтгэв.

2.2 Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын 18-64 насны нийт хүн амыг төлөөлөх чадвартай Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймаг буюу нийт 6 аймгийн интернэт ашигладаг иргэдийг судалгаанд хамруулсан. Аймгуудыг сонгохдоо бүс бүрийн хамгийн олон хүн амтай аймгийг сонгосон. Мөн түүнчлэн, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөлтэй гүнзгийрүүлсэн онлайн ярилцлагыг зохион байгуулсан.

Эм Эм Си Жи компанийн зохиогчийн эрхтэйгээр сүүлийн 7 жилийн хугацаанд гүйцэтгэж буй “Үндэсний медиа хэрэглээ”-ний судалгаанаас харахад 65 болон түүнээс дээш насны иргэдийн интернэтийн хэрэглээ бусад насны бүлэгтэй харьцуулахад бага байсан. Тиймээс түүврийн эх олонлогийг Монгол Улсын 18-64 насны иргэд байна гэж тодорхойлсон.

Үндэсний Статистикийн Хорооны 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын тоон мэдээллээр Монгол Улсад 18-64 насны 1,907,191 иргэн байна. Түүврийн хэмжээг 95%-ийн итгэх завсарт, 3%-ийн алдааны түвшинтэйгээр тооцоход түүврийн хэмжээ 1027 буюу ойролцоогоор 1030 байна.

$$n = \frac{Z^2 p(1-p)}{e^2} \quad n = \frac{(1.96)^2 \times (0.6)(1-0.6)}{(0.03)^2}$$

Энд: n – түүврийн хэмжээ, Z – хүсэж буй итгэлтэй түвшин дэх Z утга, p – тухайн үзэгдлийн илрэх магадлал, e – хүлээн зөвшөөрөгдөх алдааны түвшин

Хүн амын нас хүйсийн бүтцэд үндэслэн нас, хүйсийн квот тогтоож, энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргыг ашигласан. Нийт түүвэр нь хүйсийн хувьд тэнцвэртэй байдлаар хуваагдсан. Суурь судалгааны нийт түүврийн хэмжээг сонгогдсон аймаг, дүүргүүдэд Нейманы хуваарилалтын аргаар хуваарилсан.

³Эм Эм Си Жи ХХК нь ЭЗОМАР-ийн албан ёсны ёс зүйн стандартыг мөрдөж ажилладаг. ЭЗОМАР бол судалгааны үйлчилгээний аргачлал арга зүй, ёс зүйн хэм хэмжээ, стандартыг хөгжүүлэх чиглэлээр дэлхийн хэмжээд ажилладаг байгууллага юм. ICC/ESOMAR International Code on Market, Opinion, and Social Research and Data Analytics, <https://www.esomar.org/what-we-do/code-guidelines>

⁴ISO 20252:2019 Market, opinion and social research, including insights and data analytics — Vocabulary and service requirements, <https://www.iso.org/standard/73671.html>

Хүснэгт 1: Түүврийн хэмжээ, аймаг дүүргээр

Аймаг, дүүрэг	18-64 насны хүн ам	Түүврийн хэмжээ
Улаанбаатар – Багануур дүүрэг	17,370	29
Улаанбаатар – Багахангай дүүрэг	2,448	25
Улаанбаатар – Баянгол дүүрэг	134,162	59
Улаанбаатар – Баянзүрх дүүрэг	217,936	79
Улаанбаатар – Налайх дүүрэг	21,994	30
Улаанбаатар – Сонгинохайрхан дүүрэг	195,796	74
Улаанбаатар – Сүхбаатар дүүрэг	86,980	46
Улаанбаатар – Хан-Уул дүүрэг	108,808	53
Улаанбаатар – Чингэлтэй дүүрэг	90,066	47
Ховд аймаг – Жаргалант сум	Баруун бүс	64
Ховд - Булган сум	50,727	31
Өвөрхангай аймаг – Арвайхээр сум	Хангайн бүс	81
Өвөрхангай - Бат-Өлзий сум	68,980	23
Төв аймаг – Зуунмод сум	Төвийн бүс	73
Төв аймаг - Батсүмбэр сум	55,167	22
Дорнод аймаг – Хэрлэн сум	Зүүн бүс	80
Дорнод - Баян-Уул сум	48,924	19
Орхон аймаг – Баян-Өндөр сум	Хангайн бүс	75
Орхон - Жаргалант сум	63,898	29
Дархан-Уул аймаг – Дархан сум	Төвийн бүс	77
Дархан-Уул - Шарын гол сум	61,581	19
Нийт	1,907,191	1030

Байршлын хувьд нийт судалгааны 70%-ийг аймгийн төвийн иргэдээс, үлдсэн 30%-ийг хөдөөгийн сумын иргэдээс авахаар төлөвлөсөн. Судалгаанд гэр хороолол болон орон сууцны хороололд амьдардаг өрхүүд хамрагдсан ба нэг өрхөөс нэг судалгаа авсан. Судалгаанд 1035 иргэн хамрагдсан бөгөөд нэг хүн дунджаар 1,843 иргэнийг төлөөлж байна.

2.3 Судалгааны асуулгыг боловсруулсан байдал

Иргэдийн тоон судалгааны асуулга хэрэглэгдэхүүнийг бэлтгэхдээ **“Интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа”** нэртэйгээр нийт 8 бүлэг, 66 асуулттайгаар боловсруулсан. Асуулга хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа утсаар судалгаа авахад хялбар, хэт урт хугацаа шаардахгүй, үг хэллэг судалгаанд оролцогчид энгийн ойлгомжтой байгаа эсэхийг шалгаж, туршиж үзсэн. Судалгаа нь 25-30 минут орчим үргэлжилж байгаа бөгөөд дараах үндсэн бүлэг асуултууд, агуулгын дагуу хагас бүтэцчилэгдсэн байдлаар боловсруулагдсан. Судалгааны асуулгыг хавсралтаас үзнэ үү.

- ✓ Байршил, нас, хүйсийн квот шалгах;
- ✓ Интернэт хэрэглээ;
- ✓ Иргэдийн мэдлэг;
- ✓ Иргэдийн хандлага;
- ✓ Иргэдийн зан үйл, туршлага;



- ✓ Цахим гэмт хэрэгт өртсөн байдал;
- ✓ Мэдлэг, мэдээлэл;
- ✓ Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл.

Мөн түүнчлэн, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зарим төлөөлөлтэй гүнзгийрүүлсэн ярилцлагыг хийсэн бөгөөд интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, үйл ажиллагаа, иргэдийн энэ талаарх ойлголт мэдлэг, хандлага, технологийн боломжит байдал, асуудал бэрхшээл зэргийн талаар ярилцсан.

2.4 Судалгааны багийн зохион байгуулалт

Суурь судалгааны баг нийт 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Хүснэгт 2: Судалгааны баг бүрэлдэхүүн

Гишүүд	Тоо	Үүрэг
Багийн ахлагч	1	<ul style="list-style-type: none"> Судалгааны арга аргачлал, төлөвлөлт, зохион байгуулалтад нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих.
Судалгааны зөвлөх	4	<ul style="list-style-type: none"> Судалгааны арга аргачлал, судалгааны хэрэглэгдэхүүн, судалгааны тайланд санал зөвлөмж өгөх.
Судалгааны менежер	1	<ul style="list-style-type: none"> Судалгааны төсөв, төлөвлөлтийг хийх; Судалгааны үндсэн арга аргачлалын дагуу судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах; Судалгааны дата мэдээллийг боловсруулах; Судалгааны тайланг бичих.
Мэдээлэл цуглуулалт хариуцсан менежер	1	<ul style="list-style-type: none"> Судалгааны мэдээлэл цуглуулалтын бүх процессыг төлөвлөх, хянах, зохион байгуулах; Гэрээт судлаач, хяналтын ажилтан, шивэлтийн ажилтан нарт үүрэг даалгавар өгөх; Судалгааны процессыг удирдлагад мэдээлэх; Судалгааны мэдээлэл цуглуулалтын үед гарсан асуудал бэрхшээлийг шийдвэрлэх; Судалгааны дата мэдээллийн чанарын хяналтыг хийх, нээлттэй асуултуудыг кодолж, тайланд бэлтгэх.
Мэдээлэл цуглуулалтын хяналтын ажилтан	2	<ul style="list-style-type: none"> Судалгааны ярилцлагын 30 хувийг нэг бүрчлэн сонсож судлаач тус бүрд гаргасан алдааг сануулах; Судалгаанд оролцогч нар луу эргэн холбогдож утсаар хяналт хийх; Судалгааны үнэн бодит мэдээлэл цуглуулж байгаа эсэхэд хяналт тавих; Асуулгаа зөв асууж байгаа эсэхэд хяналт тавих; Хариултын хувилбарыг зөв тэмдэглэж байгаа эсэхэд хяналт тавих.
Шивэлтийн ажилтан	1	<ul style="list-style-type: none"> Бүх чанарын судалгааны ярилцлагын аудио сонсож шивэх.
Судлаач	30	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл цуглуулалт хариуцсан менежерийн зааварчилгааг дагаж ажлын төлөвлөгөөгөө нягт баримталж ажиллах; Тоон судалгааны оролцогчийг утсаар элсүүлэх; Тоон судалгааны ярилцлага хийх.
Нийт	40	

2.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Ковид-19 цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан, 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 6-р сарын 18-ны өдрийн хооронд “Эм Эм Си Жи” компанийн утсаар судалгаа авах төвөөс зохион байгуулсан. Утсаар судалгаа авах нь дараах үндсэн давуу талуудыг бий болгосон. Үүнд:


- ✓ Цаг хугацаа, орон зай, Ковид-19 цар тахлын хязгаарлалтаас үл хамааран мэдээллийг цуглуулах боломж бүрдүүлсэн.
- ✓ Үүрэн телефон холбооны сүлжээ нэвтэрсэн Монгол Улсын нийслэл, 9 дүүрэг, 152 хороо болон 21 аймаг, 330 сумын төв, бусад суурин газруудад нэг зэрэг хүрч, богино хугацаанд мэдээллийг цуглуулах боломжтой байсан.
- ✓ Монгол Улсын 330 сум, Улаанбаатар хотын 152 хорооны 2.5 сая идэвхтэй гар утас хэрэглэгчдийн утасны дугаарын мэдээллийн санг ашигласан
- ✓ Нэгэн зэрэг 32 гарцаар залгалт хийж, мэдээлэл цуглуулалтыг богино хугацаанд хийсэн.
- ✓ Судалгаанд оролцогчдыг түүвэрлэх үйл ажиллагаа программчлагдсан.
- ✓ Судалгаанд оролцогчийг сонгох, тэдэнтэй холбогдох, ярилцлага хийх, мэдээллийг шивж оруулах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаа автоматчилагдсан.
- ✓ Үзүүлэлтийн хязгаарыг зааж өгсөн логик шалгалт бүхий мэдээлэл оруулах программын дагуу ярилцлага явагдсанаар алдаагүй мэдээлэл цуглуулах, ярилцлагын хугацааг богиносгох боломжийг бүрдүүлсэн.
- ✓ Судалгаанд оролцогчтой хийсэн ярилцлага бүрийн аудио бичлэгийг хийж, файлын хэмжээг шахаж мэдээллийн сан бүрдүүлсэн. Ярилцлагыг бичлэгийг цуглуулсан мэдээлэлтэй тулгаж шалган мэдээллийн чанарыг шалгах үнэлсэн.



- CATI (Computer Assisted Telephone Interview)
Мэргэжлийн судалгааны программ хангамжид суурилсан телефон утсаар мэдээллийг цуглуулав.

Тоон судалгааны мэдээлэл цуглуулалтыг дараах үе шатуудын дагуу зохион байгуулсан.

Зураг 2: Мэдээлэл цуглуулалтын үе шатууд



Мэдээлэл цуглуулалтыг утсаар судалгаа авах төвөөс судалгаа авч буй явцыг Зураг.3-т дүрслэв. Мэдээлэл цуглуулагч судлаач нар зорилтот түүврийн дагуу 15,000 орчим утасны дугаар луу санамсаргүй байдлаар залгалт хийн, судалгаанд оролцогчдыг нас, хүйсийн квотоор элсүүлэн, сайн дурын үндсэн дээр судалгаанд хамруулав.


Мөн түүнчлэн, интернэтээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын зарим төлөөлөлтэй онлайнар Zoom апплекэйшн ашиглан, гүнзгийрүүлсэн ярилцлагыг хийж, зарим асуудлыг тодруулсан.

Зураг 3: Мэдээлэл цуглуулалтын явц



Утсаар судалгаа авах төв нь утасны дугаарын мэдээллийн сангаас санамсаргүй байдлаар залгалт хийж, судалгаанд оролцогчийг санамсаргүй байдлаар сонгогдох боломжийг олгосон.

Зураг 4: Утсаар судалгаа авах төвийн автомат программ хангамж



2.6 Судалгааны мэдээллийн чанарын хяналт

Нийт түүврийн хувьд системтэйгээр логик уялдаа холбоог шалгаж, шаардлагатай тохиолдолд судалгаанд оролцогчтой дахин холбогдож, тодруулга авч ажиллалаа. Мэдээллийн чанарын хяналтыг дараах гурван төрлөөр хийсэн. Үүнд:

Мэдээлэл цуглуулах судлаач нарын өөрсдийн хяналт: Судлаачийн гарын авлагад цуглуулсан мэдээллээ хэрхэн шалгах тухай зөвлөмжийг оруулсан. Тэд өдөр бүр өөрсдийн шалгалтыг хийж, оройдоо хяналтын ажилтнуудад датаг хүлээлгэн өгөх бөгөөд датанд алдаа гарсан тохиолдолд тухайн оролцогчтой холбогдож засах, эсвэл дахин нөхөж авах арга хэмжээ авсан.

Хяналтын ажилтнуудын хяналт: Орой бүр хяналтын ажилтнууд цуглуулсан мэдээлэл датаг хүлээн авсан дариудаа шалгасан бөгөөд ямар нэг алдаа илрүүлсэн тохиолдолд мэдээлэл цуглуулалтын ажилтнуудад зөвлөмж өгнө. Ямар ч алдаагүй датаг л хүлээн авсан. Мөн тэд мэдээлэл цуглуулалтын явцыг хянаж, шаардлагатай тохиолдолд судлаач нарт зөвлөмж өгч ажилласан. Бүх хяналтыг бүртгэж, мэдээллийн чанарын хяналтын тайлан бэлтгэсэн. Энэ нь датанд гарсан алдаа бүрийг бүртгэж, судлаачдад өгсөн зөвлөмжийг хүснэгт хэлбэрээр бүртгэсэн.

Мэдээлэл оруулах программын шалгалт: Мэдээлэл оруулсан программыг мэдээлэл боловсруулах шатанд мэдээлэл цуглуулалт хариуцсан менежер шалгасан. Цуглуулсан дата мэдээлэлд ямар нэг логик алдаа ажиглагдвал холбогдох алдааны протоколын хамт тэрхүү датаг мэдээлэл цуглуулалтын багт буцааж, судлаач нар судалгаанд оролцогчтой холбогдох буюу шинээр судалгаа авч тухайн алдаа бүрийг залруулж ажилласан.

Мэдээлэл цуглуулалт эхэлмэгц мэдээллийн чанарын хяналтыг судалгааны баг төв оффисоос хяналтын ажилтнууд болон мэдээлэл цуглуулалт хариуцсан менежер, мэдээлэл боловсруулах менежер нар хийж ажилласан.

Мэдээллийн чанарын хяналтыг судалгаанд оролцогчтой утсаар холбогдох, ярилцлагын аудио бичлэгийг сонсох болон цуглуулсан дата мэдээллийн логик уялдаа холбоог шалгах замаар хянасан.

Хүснэгт 3: Тоон судалгааны мэдээлэлд хяналт хийсэн хэлбэр

Хяналтын арга хэлбэр	Хяналтын хувь
Утсаар эргэн холбогдох	45%
Аудио бичлэг сонсож шалгах	30%
Логик уялдаа холбоо шалгах	100%

Судалгааны мэдээлэл цуглуулалт бүрэн дууссаны дараа цуглуулсан дата мэдээллийг кодолж, тайланд зориулан бэлтгэсэн.

Зураг 5: Хяналтын ажилтны бөглөсөн алдааны протоколын харагдах байдал

УТСААР ЯРЬЖ ЭХЛЭХДЭЭ
Сайн байна уу? Танд энэ өдрийн мэд хүргэе. Би Үндэсний судалгааны "Эм Си Жи" компаниас ярьж байна. Манай судлаач таниас ИНТЕРНЭТИЙН ЗОХИСТОЙ ХЭНГЭЛЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА авсан болов уу. Би судлаачийжаа ажлыг шалгах зорилгоор таниас хэдэн асуулт тодруулах гэсэн юм.

УТСААР ЯРЬЖ ДУУСТАХДАА
Судалгаанд оролцсон танд байрлалаа, Танд амжилт хүсье.

Судлаачийн код	Судалгааны дугаар	Залгах	Оролцогчийн нэр	Утасны дугаар	Утасны дугаар	Тэмдэглэгээ	Холболтын үр дүн 1-Холбогдсон мэдээллийг баталгаажуулсан 2-Орох ярианы эрх хаагдсан 3-Ашиглагчид байхгүй 4-Холбогдох боломжгүй 5-Утасны дээрээ түр байхгүй байгаа эргээд залгах 6-Утсаа аваагүй 7-	Судалгаа өгсөн эсэх 1. Тийм 2. Үгүй	Таны үндсэн захиргааны хаяг? Аль аймаг/нийслэлд байдаг вэ?	Таны үндсэн захиргааны хаяг? Аль аймаг/дүүрэгт байдаг вэ? 1. Мэдээлэл зөв таарсан 2. Мэдээлэл таараагүй	Таараагүй бол зөв харилтыг сонгоно уу?	Таны үндсэн захиргааны хаяг аль сум, дүүрэгт байдаг вэ?	Таны үндсэн захиргааны хаяг аль хороонд байдаг вэ? 1. Мэдээлэл зөв таарсан 2. Мэдээлэл таараагүй	Таараагүй бол зөв харилтыг сонгоно уу?	Танай өрхийн хэдэн хүнээс судалгаа авсан бэ? Тангас өөр хүнээс судалгаа авсан уу?	Таны төрсөн
17	27	Залгана	С. Дорлиг		990840				Улаанбаатар хот			Багануур дүүрэг				1996
16	16	Залгана	Ариун		955				Улаанбаатар хот			Баянгол дүүрэг				1998
10	28	Залгана	Т.Н		6				Улаанбаатар хот			Баянгол дүүрэг				2000
18	36	Залгана	Т.Г		6				Дорнод аймаг			Баян-Уул сум				1999
18	35	Залгана	Ос		6				Дорнод аймаг			Хэрлэн сум				2000
4	33	Залгана	Го		1			1	Улаанбаатар хот		1	Налайх дүүрэг				2000
4	36	Залгана	Го		1			1	Улаанбаатар хот		1	Хан-Уул дүүрэг			1	1998
18	39	Залгана	Го		6				Дорнод аймаг			Хэрлэн сум				1998
18	43	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Налайх дүүрэг				1998
9	67	Залгана	Го		6				Өвөрхангай аймаг			Бат-Өлзий сум				1977
11	25	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Хан-Уул дүүрэг				2000
10	31	Залгана	Го		6				Өвөрхангай аймаг			Арайхээр сум				1980
8	39	Залгана	Го		6			1	Төв аймаг		1	Зуунмод сум		1		1991
10	30	Залгана	Го		6			1	Улаанбаатар хот			Баянгол дүүрэг				2000
31	31	Залгана	Го		6			1	Төв аймаг		1	Зуунмод сум		1	1	1977
8	36	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Баянгол дүүрэг				2000
4	37	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Багахангай дүүрэг				2001
16	14	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Сүхбаатар дүүрэг				1998
26	31	Залгана	Го		6				Улаанбаатар хот			Баянгол дүүрэг				1998

2.7 Судалгааны анализ, дүн шинжилгээ

Ийнхүү бэлтгэсэн дата мэдээллийг ашиглан, SPSS 25 судалгааны программаар судалгааны үндсэн үр дүнгийн хүснэгтүүдийг гаргаж, хүн ам зүйн үзүүлэлтүүдээр ялгаатай байдал, нас хүйсийн онцлог хэв шинжүүдэд дүн шинжилгээ хийсэн.

Зураг 6: SPSS программ дээр судалгааны дата харагдах байдал

id	S1	S2_SUM	S3	S4	S5	S6	S6_OTHER	A2_1	A2_1.1	A2_1.2	A2_1.3	A2_1.4	A2_1.5	A2_2
1	693	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг	Эмэгтэй	1973	45-54	Монгол гэр	Гар утсаар	Гар утсаар						QSFBDJG
2	584	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Эмэгтэй	1988	30-34	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						FTJOIENPGLQRABSKD
3	535	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг	Эрэгтэй	1989	30-34	Орон сууц	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					EBSG
4	254	Дархан-Уул аймаг Дархан сум	Эмэгтэй	1970	45-54	Орон сууц	АС	Ширээний ко...	Гар утсаар					CMFHTKJBESALFDQ
5	382	Улаанбаатар хот Баянгол дүүрэг	Эмэгтэй	1970	45-54	Орон сууц	АС	Ширээний ко...	Гар утсаар					EG
6	691	Орхон аймаг Баян-Өндөр сум	Эмэгтэй	1971	45-54	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						Ажил хийх
7	688	Дорнод аймаг Хэрлэн сум	Эрэгтэй	2000	18-29	Хашаа байшин	BCD	Неүтбүүк (не...	Гар утсаар	Таблетаар...				BQS
8	689	Хөвд аймаг Булган сум	Эмэгтэй	1996	18-29	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						GREBS
9	692	Дорнод аймаг Хэрлэн сум	Эмэгтэй	1987	30-34	Орон сууц	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					Мэдээ, мэдээлэл авах
10	687	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Эмэгтэй	1966	55-64	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						TBE
11	686	Хөвд аймаг Жаргалант сум	Эрэгтэй	1966	55-64	Орон сууц	Ширээний	Ширээний ко...						CJDSLFB
12	252	Улаанбаатар хот Багануур дүүрэг	Эрэгтэй	1970	45-54	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						EBST
13	681	Орхон аймаг Баян-Өндөр сум	Эрэгтэй	1975	45-54	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						SEDC
14	680	Дорнод аймаг Хэрлэн сум	Эмэгтэй	1960	55-64	Монгол гэр	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					Facebook ашиглах
15	685	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүү...	Эрэгтэй	2000	18-29	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						CE
16	683	Орхон аймаг Баян-Өндөр сум	Эрэгтэй	1984	35-44	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						EB
17	684	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүү...	Эмэгтэй	1992	18-29	Орон сууц	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					JDISKBE
18	363	Өвөрхангай аймаг Арайхээр сум	Эрэгтэй	2001	18-29	Монгол гэр	Гар утсаар	Гар утсаар						CAEBNGFHLPDOSQ
19	694	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүү...	Эрэгтэй	1984	35-44	Хашаа байшин	CE	Гар утсаар	Смарт зурагт...					DE
20	706	Төв аймаг Зуунмод сум	Эрэгтэй	1989	30-34	Монгол гэр	Гар утсаар	Гар утсаар						Мэдээ, мэдээлэл авах
21	19	Өвөрхангай аймаг Арайхээр сум	Эрэгтэй	1957	55-64	Хашаа байшин	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					ES
22	695	Дорнод аймаг Хэрлэн сум	Эрэгтэй	1969	45-54	Монгол гэр	Гар утсаар	Гар утсаар						SRHEJCPMDFQBNT
23	439	Дархан-Уул аймаг Дархан сум	Эмэгтэй	1991	30-34	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						JCGBHDQSLMNPKAFET
24	364	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Эрэгтэй	1998	18-29	Орон сууц	Гар утсаар	Гар утсаар						LQHSPTCRDKMANBJOF
25	704	Хөвд аймаг Жаргалант сум	Эмэгтэй	1985	35-44	Монгол гэр	BCSE	Неүтбүүк (не...	Гар утсаар	Смарт зу...				EBN
26	716	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Эмэгтэй	2003	18-29	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						GQJSTOMKENCIFPHLR
27	711	Өвөрхангай аймаг Арайхээр сум	Эрэгтэй	1986	35-44	Монгол гэр	CE	Гар утсаар	Смарт зурагт...					ESBHMFKJQFCDLTNG
28	710	Дорнод аймаг Хэрлэн сум	Эмэгтэй	1999	18-29	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						STQRFBG
29	577	Улаанбаатар хот Багануур дүүрэг	Эмэгтэй	1982	35-44	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						GDBFTQ
30	119	Дорнод аймаг Хэрлэн сум	Эрэгтэй	1990	30-34	Хаус	ABCODE	Ширээний ко...	Неүтбүүк (не...	Гар утсаар	Таблетаар...	Смарт зурагт...		GDBFTQ
31	389	Хөвд аймаг Жаргалант сум	Эмэгтэй	1982	35-44	Хашаа байшин	АС	Ширээний ко...	Гар утсаар					JCDBQP
32	713	Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг	Эрэгтэй	1976	45-54	Хашаа байшин	АС	Ширээний ко...	Гар утсаар					BC
33	554	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг	Эмэгтэй	1993	18-29	Орон сууц	BC	Неүтбүүк (не...	Гар утсаар					CSBEK
34	674	Өвөрхангай аймаг Арайхээр сум	Эрэгтэй	1980	35-44	Хашаа байшин	ACE	Ширээний ко...	Гар утсаар	Смарт зу...				FDBC
35	672	Улаанбаатар хот Баянгол дүүрэг	Эрэгтэй	1990	30-34	Хаус	ABCODE	Ширээний ко...	Неүтбүүк (не...	Гар утсаар	Таблетаар...	Смарт зурагт...		ATCDBFIG
36	702	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүү...	Эрэгтэй	2003	18-29	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						CBU
37	705	Дархан-Уул аймаг Дархан сум	Эрэгтэй	1988	30-34	Хашаа байшин	Гар утсаар	Гар утсаар						MHPFRKAJTGBINOCLOE

Судалгааны асуулгад үндэслэн, Мэдлэг, Хандлага, Туршлагын индексүүдийг тус тус тооцоолон, статистик шинжилгээний хүчин зүйлсийн шинжилгээ, (factor analysis, correlation, regression), K-means кластер анализ, Chi-square тест зэрэг дүн шинжилгээний аргуудыг ашиглан КАП судалгааны хамаарлын дүн шинжилгээг хийж гүйцэтгэв.



ХУРААНГУЙ ҮР ДҮН

3



13. ХУРААНГУЙ ҮР ДҮН

Судалгааны үр дүнг хураангуй байдлаар дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4: Судалгааны хураангуй үр дүнгийн хүснэгт

Дүгнэлт			
<i>Интернэтийн хэрэглээ:</i>	Бүх насны иргэдийн интернэт хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байна. Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл ойлголт хангалттай, зөв хандлагатай байна. Гэвч, интернэтийг өдөрт олон цагаар ашиглаж байна.		
<i>Мэдээллийн технологийн аюулгүй байдал</i>	Интернэт орчинд өөрийн болон гэр бүлийнхнийхээ аюулгүй байдлыг хамгаалах технологийн шийдлүүдийг мэддэг байдал иргэдийн нас нэмэгдэх тусам багасаж байна.		
<i>Насны бүлэг:</i>	18-24 насныхан	25-45 насныхан	45+ насныхан
<i>Ерөнхий хэв шинж:</i>	Цахим орчны хэрэглээ маш өндөр, технологийн тохиргоонуудын талаар маш сайн мэддэг боловч интернэт орчинд иргэд соёлтой байж чаддаггүй гэж үздэг. Технологийн аргуудыг харьцангуй сайн ашиглаж байгаа боловч цахим гэмт хэрэгт өртсөн тохиолдолд юу хийхээ мэдэхгүй.	Цахим орчны хэрэглээ өдөр тутмын ажил, амьдралын нэг хэсэг болсон, эцэг эх нь хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавих үүрэгтэй гэж үздэг. Гэвч технологийн үндсэн хамгаалах аргуудыг тэр бүр мэдэхгүй, аль болох зөв зохистой хэрэглэхийг хичээдэг боловч интернэтийн хэрэглээ өндөр байна.	Ялангуяа Фэйсбүүкийг идэвхтэйгээр ашиглаж байгаа. Цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах тухай технологийн талаарх мэдлэг ойлголт маш бага, цахим орчин аюул эрсдэлтэй байж болохыг сайн ойлгоогүй байна.
<i>Зарим онцлох үзүүлэлтүүд</i>			
Нийт хүн ам дахь интернэт хэрэглэгчийн хувь хэмжээ			61%
Сүүлийн 10 жил дэх интернэт хэрэглээний өсөлт			34%
Кибер аюулгүй байдлын индекс ⁵			46.5
Нэг өдөрт интернэт хэрэглэж буй дундаж хугацаа			7 цаг 13 минут
Гар утас хэрэглэж байгаа хүн амын хувь			142%
Мэдлэг: Залуучуудын интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх ойлголт мэдлэг сайн байна. 45-аас дээш насны иргэдийн хувьд мэдлэг, ойлголтыг нь нэмэгдүүлэх шаардлагатай.			
<i>Мэдлэг</i>	Монгол Улсад +18 сайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вэбсайтыг хаадаг болохыг мэддэг		43%

⁵ Кибер аюулгүй байдлын индекс нь Олон улсын мэдээллийн технологийн холбооноос дэлхийн хэмжээнд улс орнуудын кибер аюулгүй байдлын талаарх ойлголт, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилготойгоор жил бүр гаргадаг үзүүлэлт юм. Улс орон бүрийн кибер аюулгүй байдал янз бүрийн салбар, үйл ажиллагаанд ялгаатай байдаг тул уг үзүүлэлтийг үндсэн 5 бүлгээр хэмжиж тооцдог. Үүнд 1.Хууль эрхзүйн орчин, 2.Техникийн бэлэн байдал, 3.Зохион байгуулалт, 4. Ур чадварын хөгжил, 5. Хамтын ажиллагаа. Global Cybersecurity index, International Telecommunications Union, <https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx>

	Цахим орчинд өөрийгөө хамгаалах ядаж нэг үйлдэл мэддэг	87%
	Үл таних хүнээс ирсэн линк, холбоосыг нээж үзэж болохгүй гэдгийг мэддэг	78%
	Фэйсбүүкийн профайл дахь зураг, нас, хүйс нь хуурамч байж болно гэдгийг мэддэг	70%
	Public/private тохиргооны ялгааг мэддэг	41%
	Өөрийн социал хаягаа өөр ямар төхөөрөмжүүд дээр нэвтэрсэн байгааг шалгаж мэднэ	37%
<p>Хандлага: Иргэд интернэтийг зүй зохистой хэрэглэх хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байна. Тэд өөрсдийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавихыг хичээдэг зөв хандлагатай байна. Гэвч, интернэт орчинд иргэд соёлгүй байна гэж үзэв.</p>		
<i>Хандлага</i>	Өөрийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавихыг хичээдэг	85%
	Иргэд социал орчинд соёлтой байж чаддаггүй	85%
	Хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавих нь эцэг эхчүүдийн үүрэг	98%
	+18 сайт болон оюуны өмчийн зөрчилтэй кино сайтад хязгаарлалт хийсэн нь зөв	93%
	Цахим орчинд нууц үг үүсгэхдээ аль болох өөрт эргэн санахад хялбар зөвхөн тоо эсвэл тэмдэгт ашиглах нь амар	88%
	Төлбөртэй программ хангамжуудыг үнэгүй ашиглах боломж байхад заавал худалдаж авах шаардлагагүй	84%
<p>Туршлага: Иргэд интернэтийг хэт их хэрэглэж, эрүүл мэндээ эрсдэлд оруулж байна. Тэд боломж нь олдвол зохиогчийн эрхийн зөрчилтэй контентыг үзэж, төлбөртэй программыг үнэгүй татаж байна. Интернэт орчинд өөрийгөө хамгаалах технологийн шийдлүүдийг тогтмол ашиглахгүй байна.</p>		
<i>Туршлага</i>	Цаг үеийн мэдээ, мэдээлэл авах зорилгоор интернэт ашигладаг	71%
	Гар утас, бусад төхөөрөмжийн хэт их хэрэглээнээс болж нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал тулгардаг	79%
	Кино, драма зэрэг зохиогчийн эрхтэй контентыг интернэтээр үнэгүй үздэг	54%
	Өглөө босоод шууд социал хаягаа шалгадаг	62%
	Хоол идэж байхдаа интернэт ашигладаг	49%
	Төхөөрөмжийн программын шинэчлэлийг тогтмол хийдэг иргэдийн хувь	19%
	Интернэт орчинд байгаа мэдээлэл хуурамч эсэхийг мэдээллийн эх үүсвэрийг шалгаж үздэг	51%
	Цахим хаягийн нууц үгээ 6 сар тутам сольдог	38%
<p>Иргэдэд өөрсдөд нь болон эргэн тойрны хүмүүст нь цахим гэмт хэрэгт өртсөн тохиолдол харьцангуй олон тохиолдсон байна. Цахим гэмт хэргийн аюул эрсдэлийг тэд дутуу үнэлж байна. Мөн цахим гэмт хэргээс сэргийлэх арга замуудыг хангалттай сайн ашиглахгүй байна.</p>		
<i>Цахим гэмт хэрэгт өртсөн байдал</i>	Социал орчинд байршуулсан зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл (зүй бус бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) авч байсан	29% (560,190 иргэн)
	Социал медиа, имэйлээ хакердуулсан	22% (424,721 иргэн)

Өөрийг нь айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас танихгүй хүнээс авч байсан	17% (333,479 иргэн)
Интернэт, нийгмийн сүлжээгээр эсрэг хүйсийн хүнээс +18 агуулгатай зураг, бичлэг хүлээн авч, садар самуунд уруу татахыг оролдож байсан	17% (326,342 иргэн)
Таньдаг хүнээс ирсэн линк дээр дарсны улмаас банкны КАПтаасаа өөрийн мэдэлгүй мөнгө суутгуулж хохирч байсан	17% (331,896 иргэн)
Онлайн худалдааны луйварт өртсөн	14% (261,151 иргэн)
Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ цагдаагийн байгууллагад мэдэгдсэн	39% (381,079 иргэн)

Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн мэдлэг ойлголт сайн, хандлага зөв талдаа байгаа боловч интернэтийг зохисгүй хэрэглэж байна.


Тэд цахим гэмт хэргийн аюул эрсдэлийг бүрэн ойлгоогүй тул эрсдэлийг дутуу үнэлж байна. Тиймээс өөрсдийгөө цахим гэмт хэрэгт өртөж болзошгүй бодит эрсдэл бий гэдгийг ухамсарлаагүй байна. Мөн цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд яг юу хийх ёстойгоо мэдэхгүй байна.

Тиймээс иргэдийг өдөр тутамдаа интернэтийг зохистой хэрэглэх, мэдээллийн технологийн аюулгүй байдлаа тогтмол хангах үйлдлүүдийг хийдэг болгоход уриалах шаардлагатай. Иргэдэд мэдээлэл сурталчилгаа хүргэхдээ төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, сошиал платформуудтай хамтран, нэгдсэн цогц байдлаар мэдээлэл сурталчилгаа хийвэл зохимжтой байна.



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4



I4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Интернэтийн хэрэглээ, бусад улстай харьцуулсан байдлаар

Бүлгийн дүгнэлт:

- Монгол Улсад интернэтийн хэрэглээ маш хурдацтай нэмэгдэж байна. Энэ нь аль хэдийн **дэлхийн дунджаас 1 пунктээр давсан, Төв Азийн улсуудаас 3 пунктээр илүү** байгаа бөгөөд хүн амын өсөлттэй уялдан улам нэмэгдэх төлөвтэй байна.
- Монгол Улсын **нийт хүн амын 142% нь гар утас хэрэглэж байгаа** бөгөөд энэ нь **дэлхийн дунджаас даруй 2 дахин илүү**, Азийн бусад орнуудтай харьцуулахад өндөр, Зүүн Европын улсуудтай эн зэрэгцэх хэмжээний үзүүлэлттэй байна. Үүнээс гар утасныхаа 4G/LTE сүлжээг ашиглан интернэтэд холбогддог иргэдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь дэлхийн трендтэй ижил байна.
- Монголчуудын 6+ насны иргэд интернэтийг идэвхтэй хэрэглэж байгаа бөгөөд **сүүлийн 10 жилд интернэт хэрэглээ 34.1%-аар өссөн** байна. Одоогоор хотод амьдардаг иргэдийн 4 хүн тутмын 3, хөдөөгийн иргэдийн 2 хүн тутмын 1 нь интернэт хэрэглэж байна.
- Сошиал медиа хэрэглээ эрчимтэй өсөж, өдөр тутмын мэдээ мэдээллийг уламжлалт медиа хэрэгслүүдээс илүү интернэт орчноос авах нь элбэг болж байна.
- Иргэдийн интернэтийн хэрэглээ эрчимтэй өсөж, **хэрэглэгчийн бэлэн байдлын түвшнээр харьцангуй сайн** байгаа боловч **кибер аюулгүй байдлын хувьд хөрш орнуудаасаа харьцангуй бага түвшинд** байна.
- 18-64 насны Монгол хүн **нэг өдөрт дунджаар 7 цаг 13 минутыг интернэт орчинд өнгөрөөж байгаа** нь дэлхийн дунджаас 4 минутаар илүү, Хятад, Энэтхэг улсуудын иргэдийн хэрэглээнээс их байна. Мөн **нэг өдөрт интернэтээр видео тоглоом тоглох хугацаа нь 2 цаг орчим** байгаа нь Хятад улсынхаас 37 минутаар, ОХУ-ынхаас 1 цаг 25 минутаар илүү байна.

Дэлхийн бүс нутаг бүрийн гар утас болон интернэт хэрэглэгчдийн тоог нийт хүн амд нь харьцуулсан статистикийг гаргасан байдаг⁶. Уг үр дүнгээс харахад төв Азийн нийт хүн амын 98% нь гар утас хэрэглэдэг бол Монголчуудын хувьд энэ үр дүн 142% байна. Өөрөөр хэлбэл Монголд гар утасны давхар хэрэглээ их байгаа юм. Монголчуудтай адил гар утасны давхар хэрэглээ ихтэй орнуудад Зүүн Өмнөд Азийн улсууд, Зүүн Европын улсууд, Өмнөд Африкийн улсууд багтаж байна. Харин Америк, Европ тивийн улсууд давхар гар утасны дугаар ашиглах хандлага харьцангуй бага байна.

Дэлхийн хүн амын 60% нь интернэт хэрэглэдэг байхад Монголчуудын 61% буюу 2.0 сая хүн интернэт хэрэглэдэг гэж уг тайланд дурджээ. Монголчуудын интернэтийн хэрэглээний түвшин төв Азийн улсуудаас 1 пунктээр, өмнөд Азийн улсуудаас 19 пунктээр, Зүүн Африкийн улсуудаас 37 пунктээр тус тус илүү байгаа боловч Европ, Америкийн улсуудаас бага байна.

⁶ <https://datareportal.com/reports/digital-2021-mongolia>

Хүснэгт 5: Гар утас, интернэтийн хэрэглээ, дэлхийн дундажтай харьцуулсан байдлаар

Байршлаар	Нийт хүн амд интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь	Нийт хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь
Хойд Европын улсууд	96%	113%
Баруун Европын улсууд	93%	118%
Төв Америкийн улсууд	90%	97%
Өмнөд Европын улсууд	86%	125%
Зүүн Европын улсууд	82%	146%
Баруун Азийн улсууд	74%	98%
Өмнөд Америкийн улсууд	72%	103%
Зүүн Өмнөд Азийн улсууд	69%	132%
Зүүн Азийн улсууд	68%	115%
Хойд Америкийн улсууд	67%	106%
КАПибын тэнгисийн улсууд	67%	77%
Өмнөд Африкийн улсууд	62%	163%
Монгол Улс	61%	142%
Дэлхийн дундаж	60%	67%
Төв Азийн улсууд	57%	98%
Хойд Африкийн улсууд	56%	100%
Өмнөд Азийн улсууд	42%	85%
Дундад Африкийн улсууд	26%	55%
Зүүн Африкийн улсууд	24%	62%

Монгол Улсын интернэт хэрэглээ, тэр дундаа социал медиа хэрэглээ эрчимтэй өсөж байна. Хүснэгт-6-д интернэт хэрэглээний зарим үзүүлэлтийг зарим улсуудтай харьцуулан харуулав. Монгол Улс 100,000 хүн ам тутмын интернэт хэрэглэгчийн тоогоор дэлхийн дунджийг давсан, мобайл сүлжээний дэд бүтцээрээ харьцангуй сайн боловч кибер аюулгүй байдлын индекс, төхөөрөмж, үйлчилгээний хүртээмжтэй байдлаараа бусад хөрш улс орнуудаас харьцангуй бага байна.

Хүснэгт 6: Монгол Улсын интернэт хэрэглээ, зарим улс оронтой харьцуулсан байдлаар

Үзүүлэлтүүд	Дэлхийн дундаж	Монгол	Хятад	ОХУ	Казак стан	Энэтхэг	
I. Интернэт хэрэглээ							
1.1	100,000 хүн ам тутмын интернэт хэрэглэгчийн тоо	59,500	61,000	68,500	85,000	81,900	45,000
1.2	Мобайл сүлжээнд холбогдсон хүн амын хувь хэмжээ	102.4%	141.8%	111.8%	156.7%	129.4%	79.0%
1.3	Гар утсаар интернэтэд холбогдож байгаа хувь хэмжээ	55.7%	51.2%	61.6%	26.0%	45.6%	76.6%

Үзүүлэлтүүд	Дэлхийн дундаж	Монгол	Хятад	ОХУ	Казак стан	Энэтхэг
1.4 Гар утасны мобайл датагаар (3G-5G) интернэтэд холбогдож буй хувь хэмжээ	81.7%	71.2%	94.0%	83.1%	82.7%	67.9%
1.5 Мобайл холболтын индекс	61.0	58.0	76.0	74.9	67.5	56.6
1.6 Мобайл сүлжээний дэд бүтэц	-	60.2	76.5	63.3	58.1	55.3
1.7 Төхөөрөмж, үйлчилгээний хүртээмжтэй байдал	-	53.1	68.9	74.1	78.0	66.4
1.8 Хэрэглэгчийн бэлэн байдал	-	83.2	78.2	88.5	79.8	48.3
1.9 Контент, үйлчилгээний хүртээмж ⁷	-	42.6	81.0	75.8	57.3	57.8
1.10 Онлайнаар худалдан авалт хийдэг эсвэл төлбөрөө төлдөг хүн амын эзлэх хувь	29.0%	17.1%	48.8%	39.6%	24.3%	4.3%
1.11 Мобайл интернэт холболтоор татах дундаж хурд (MBPS)	47.2	18.4	155.9	24.2	19.5	12.9
1.12 Кибер аюулгүй байдлын индекс	-	46.5	82.8	83.6	77.8	71.9
II. Сошиал медиа хэрэглээ						
2.1 100,000 хүн амын тутмын идэвхтэй сошиал медиа хэрэглэгчдийн тоо	53,600	78,700	64,600	67,800	63,500	32,300
2.2 Хөдөлгөөнт төхөөрөмжөөр ФБ ордог хэрэглэгчдийн хувь	98.3%	99.1%	93.4%	95.1%	98.9%	99.5%
2.3 Лайк дарсан ФБ хуудсын тоо	1	3	-	1	1	1
2.4 Сүүлийн 30 хоногт лайк дарсан постын тоо	11	18	-	4	4	13
2.5 Сүүлийн 30 хоногт коммент бичсэн тоо	5	11	-	1	1	3
2.6 Сүүлийн 30 хоногт шэйр хийсэн тоо	1	5	-	1	1	1
2.7 Сүүлийн 30 хоногт дарсан ФБ зарын тоо	11	18	-	9	12	7
2.8 Нэг өдөрт дунджаар интернэтэд зарцуулах хугацаа	6:56	7:00*	5:22	7:52	-	6:36
2.9 Нэг өдөрт сошиал медиа ашиглаж байгаа дундаж хугацаа	2:22	2:00*	2:04	2:28	-	2:25

⁷ Контент үйлчилгээний хүртээмж нь дэлхийн мобайл утасны операторуудын холбоо олон улсын хэмжээнд тооцдог, харьцуулах боломжтой үзүүлэлт юм. Availability of relevant content and services, GSMA, <https://www.gsma.com/r/wp-content/uploads/2020/09/GSMA-State-of-Mobile-Internet-Connectivity-Report-2020.pdf>


Үзүүлэлтүүд	Дэлхийн дундаж	Монгол	Хятад	ОХУ	Казак стан	Энэтхэг
2.10 Нэг өдөрт видео тоглоом тоглож байгаа дундаж хугацаа	1:10	1:58*	1:21	0:33	-	1:20

Эх үүсвэр: Datareportal 2021 тайлангууд, ХХЗХ статистик

Интернэт хэрэглээний өсөлт

Суурин эсвэл хөдөлгөөнт сүлжээгээр интернэтэд холбогдохыг интернэт ашигласан гэж тодорхойлон 2 хувааж үзсэн байдаг. Ингэхэд Монгол Улсын хүн амын 64.7% нь интернэт хэрэглэж байгаа нь 2010 онтой харьцуулахад 34.1 пунктээр нэмэгдсэн байна. Интернэт хэрэглэдэг хүн амын 58.7% нь байнга ашигладаг бол 41.3% нь шаардлагатай үедээ буюу интернэт кафе, найз нөхөд, бусад хүмүүсийн интернэтэд холбогдсон шугамаар интернэт ашиглаж байна. Энэ нь интернэтийн хэрэглээ сүүлийн 10 жил маш ихээр нэмэгдсэнийг харуулж байгаа ба COVID-19 цар тахлын нөлөө нь интернэт хэрэглээний өсөлтийн томоохон шалтгаан болсон байх магадлалтай юм. Байршлын хувьд хот, сууринд амьдардаг б, түүнээс дээш настай хүн амд интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь өндөр буюу 72.4%-тай байна.


Зураг 7: Зургаа, түүнээс дээш настай хүн амд интернэт хэрэглэгчдийн эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2020 он



6, түүнээс дээш настай интернэт хэрэглэгчдийг хүйсээр харахад эмэгтэйчүүдийн 66.6%, эрэгтэйчүүдийн 62.7% нь хэрэглэдэг байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харахад 6-9 нас, 70, түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их, харин бусад насны бүлгийн хувьд эмэгтэйчүүд их байна. Тухайн насны бүлэгтээ хамгийн их интернэт ашигладаг бүлэг нь 15-24 насныхан байна.

* Суурь судалгааны үр дүнгээс тооцоолов. Асуулт 2.3

Зураг 8: Зургаа, түүнээс дээш насны хүн амын интернэтийн хэрэглээ, нас, хүйсийн суварга



Интернэтийн хэрэглээ нь одоогийн амьдарч буй сууцны нөхцөлтэй шууд хамааралтай. Учир нь орон сууцанд амьдардаг өрхүүдийн дэд бүтцийн хангамж нь гэр хорооллын бүсэд амьдардаг өрхүүдтэй харьцуулахад илүү байдаг. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 897.4 мянган өрх 770.9 мянган сууцанд амьдарч байна. Нийт өрхийн 67.6% нь хотод, 32.4% нь хөдөө амьдарч байна. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 29.4%-ийг эзэлж байгаа нь 2010 оныхоос 8.1 пунктээр нэмэгдсэн буюу сүүлийн 10 жилд орон сууцанд амьдардаг айл өрхүүд 112.0 мянгаар нэмэгджээ.

Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ИҮҮ) тусгай зөвшөөрөлтэй компаниудын гэрээт интернэт хэрэглэгчийн тоог доор харуулав. 2020 оны байдлаар 307.2 мянган гэрээт интернэт хэрэглэгч⁹ байгаа ба үүний 287.9 мянга нь өрхийн хэрэглэгч байна. Монгол Улсад 897.4 мянган өрх байгаатай харьцуулж үзвэл нийт өрхийн 32.1% нь буюу 3 өрх тутмын 1 нь гэртээ интернэттэй байна. Энэ үр дүн Улаанбаатар хотод 51%, орон нутагт 16% байна. Үүнийг аймгаар задлан харвал, Орхон аймагт хамгийн өндөр байгаа бол Завхан аймагт интернэтийн нэвтрэлт хамгийн бага байна.

Хүснэгт 7: Өрхийн тоо, өрхийн интернэт хэрэглэгчийн тооны харьцуулалт, 2020 он

Байршлаар	Өрхийн тоо	Гэрээт өрхийн интернэт хэрэглэгчийн тоо	Гэрээт интернэтийн нэвтрэлт
Монгол Улсын хэмжээнд	897,427	287,942	32%
Улаанбаатар хот	411,420	209,828	51%
Орон нутаг	486,007	78,114	16%

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат хүн ам 3,296,866 болсон ба үүнээс 3,174,565 (96%) нь Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байна¹⁰. Сүүлийн 10 жилд бүх аймаг, нийслэлийн хүн ам жилд дунджаар 0.9-өөс 3.9 хувиар өссөн нь төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, Монгол Улсын хүн ам

⁹ Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, 2020 он

¹⁰ Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо


2020 онд 1918 оноос 5 дахин, 2010 оноос хойш жилд дунджаар 2.2 хувиар өсжээ. Гэхдээ 1989 оноос хойших аймаг, нийслэлийн хүн амын өсөлт эрс ялгаатай байна. Сүүлийн 30 жилд хүн амын голч нас 18.8-аас 27.9 болж бараг 10 жилээр хойшилсон нь төрөлтийн бууралтаас гадна дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой.

Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45.9 хувь нь Улаанбаатар хотод, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь Баруун бүсэд, 7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна. Ардчилал гарснаас хойш буюу 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн төв, суурин газар луу шилжилт сүүлийн 30 жилд үргэлжилсэн хэвээр байна. Төв, суурин газруудад дэд бүтцээр хангагдсан байдал, боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж, ялангуяа ажил, орлоготой болох найдвартай эх үүсвэр болж байгаа нь иргэдийг ихээр татаж, хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоог үндэслэн тооцсон Монгол Улсын харьяат хүн ам 2045 онд 4.9 саяд хүрэхээр байна. Харин Монгол Улсын харьяат хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан хувилбараар 2045 онд 5.0 сая болно гэсэн тооцоо гарсан¹¹. Монгол Улсын харьяат хүн амын тоог насны бүтцээр харахад 0-14 насны хүүхдийн эзлэх хувь 30 орчим хувьтай байхаар байна. Харин 65-аас дээш настай хөгшчүүдийн эзлэх хувийн жин тодорхой хувиар өсөхөөр байна. Тухайлбал, 2015 онд 65-аас дээш насныхан нийт хүн амын 3 хувийг эзэлж байсан бол 2045 онд 9 хувь болж 3 дахин нэмэгдэхээр байна.

Хүн амын тоо нэмэгдэх төлөвтэй байгаа нь иргэдийн интернэтийн хэрэглээ ч мөн адил дагаад улам нэмэгдэхийг анхааруулж байна.

Зураг 9: Хүн амын тоо, насны бүлэг, хувийн жингээр, 1963-2045 он



Гар утасны хэрэглээний өсөлт


Монгол Улсын 6, түүнээс дээш насны хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэдэг ба энэ нь 2010 онд хийсэн тооллогоос 13.8 пунктээр өсжээ. Аймаг, нийслэлийн 6, түүнээс дээш настай хүн амд гар утас хэрэглэгчдийн эзлэх хувь Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймгуудад улсын дунджаас өндөр байна. Харин Баян-өлгий аймагт гар утасны

¹¹ Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, Үндэсний Статистикийн Хороо, 2017 он

хэрэглээ хамгийн доогуур буюу 76.3 хувьтай байна. Энэ нь орчин үеийн харилцаа холбооны техник, технологи харьцангуй богино хугацаанд өргөн нэвтэрч суурьшил хоорондын ялгаа нь багасаж байгааг илэрхийлж байгаа юм.

Насны хувьд авч үзвэл 15-69 насныхны гар утасны хэрэглээ 94 хувиас дээш байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин 6-9 насныхны 37.2 хувь нь гар утастай байна. 6, түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн 88.9 хувь нь, эрэгтэйчүүдийн 86.5 хувь нь гар утас хэрэглэж байна. Гар утас хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс 2.4 пунктээр илүү байна.

Зураг 10. Гар утас хэрэглэдэг хүн ам, насны бүлгээр, хувиар




Эх үүсвэр: ҮСХ, 2020 оны хүн амын ээлжит тооллого

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2020 оны жилийн эцсийн тоон статистикаас харахад Монгол Улсын хэмжээнд үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2016 оноос хурдацтай нэмэгдсэн ба үүрэн холбооны дата ачаалал эрчимтэй өсөж байна. Үүрэн холбооны хөдөлгөөнт LTE/4G өргөн зурвасын хэрэглэгчийн тоо 2020 оны жилийн эцсийн байдлаар 2,365.1 мянга болж сүүлийн 5 жилд 10.9 дахин нэмэгджээ. LTE/4G өргөн зурвасын хэрэглэгчийн тоо цаашид ч өсөх хандлагатай байгаа ба зөвхөн 2020 онд л гэхэд өмнөх оноос 408.3 мянган буюу 21 хувиар өссөн байна. Харин 3G хэрэглэгчийн тоо сүүлийн 5 жилд тогтвортой нэмэгдсээр 3,294.3 мянгад хүрсэн байна¹². 2020 оны байдлаар хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээг харвал 4G/LTE хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ нь 3G хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээнээс 4.2 дахин их байна.

¹² Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үзүүлэлтүүд, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, 2020 он

График 1: Үүрэн холбооны дата ачаалал, оноор, терабайт



Эх үүсвэр: Харилцаа холбооны зохицуулах хорооны статистик


Үүнээс үзэхэд хүн амын өсөлт, техник технологийн дэвшилтэй хамт Монгол Улс дахь интернэт хэрэглэгчийн тоо, гар утасны хэрэглээ болон дата хэрэглээний ачаалал улам нэмэгдэж байна. Энэ цаг үед цахим хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг танин мэдэх, хандлагыг тодорхойлж, туршлага зан үйлийг шалгаж үзэх нь нэн чухал юм.

4.2 Интернэтийн зохистой хэрэглээний талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага

Бүлгийн дүгнэлт:

- Иргэдийн **10 хүн тутмын 6 нь Public/private тохиргооны ялгааг мэдэхгүй, өөрийн хаягаа ямар ямар төхөөрөмж дээр нэвтэрсэн байгааг мэдэхгүй** байна.
- Иргэдийн 43.1% нь Монгол Улсад +18 сайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вэбсайтыг хаадаг болохыг мэдэж байгаа бөгөөд 93.1% нь энэ зохицуулалтыг дэмжиж байна.
- Тэдний **85.2% нь иргэд социал орчинд соёлтой байж чаддаггүй** гэдэгтэй санал нийлж байгаа бөгөөд **10 хүн тутмын 9 нь эцэг эхчүүд хүүхдүүдээсээ илүү социал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал** болж байна гэж үзэж байна.
- Иргэдийн **87.5% нь цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд хийж болох ядаж нэг үйлдлийг мэдэж байгаагаас** нууц үгээ тогтмол солих аргыг хамгийн сайн мэдэж байна. Тэд интернэтийн зохисгүй хэрэглээнээс үүдэх эрүүл мэндийн эрсдэлүүдийг маш сайн мэдэж байна.
- Иргэдийн насны бүлэг нэмэгдэх тусам эсвэл боловсролын түвшин буурах тусам мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн түвшин буурч байна.


Зураг 11: Мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг



Иргэдийн мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг харьцангуй сайн байна. 10 хүн тутмын 9 нь онлайнаар төрөл бүрийн сонжоо, таавар, азаа үзэх зэрэг нь аюултай гэдгийг, 10 хүн тутмын 7 нь Фэйсбүүкийн профайл хуурамч байж болно гэдгийг мэдэж байна. Сошиал хаяг болон банкны нууц үг ижил байж болохгүй гэдгийг 10 хүн тутмын 6 нь мэддэг. Харин 10 хүн тутмын 4 нь хуучин загварын төхөөрөмж ашиглах нь эрсдэл бий болгох бөгөөд Монгол Улсад +18 агуулгатай вэбсайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вебсайтуудыг хаадгийг мэдэж байна.

Аюулгүй байдлаа хамгаалах илүү нарийн техникийн тохиргоонуудыг залуучууд сайн мэддэг бол 45-аас дээш насны иргэд тэр бүр мэдэхгүй байна. Хувийн нууцлал хангах анхан шатны тохиргоо болох Public/private тохируулгыг 10 хүн тутмын 6 нь мэдэхгүй байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна.

Зураг 12: Технологийн тохиргоонуудыг мэддэг байдал




Эх үүсвэр: Асуулт 3.1 – 3.11

18-64 насны иргэдийн 43.1% нь Монгол Улсад +18 сайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вэбсайтыг хаадаг болохыг мэдэж байна. Эрэгтэйчүүдийн 47.1%,

эмэгтэйчүүдийн 39.2% нь энэ талаар мэдэж байгаа бол орон сууцанд амьдардаг болон дээд боловсролтой 2 иргэн тутмын нэг нь мэдэж байна. Насны бүлгээр нь харахад, нас ахих тусам интернэтэд зохицуулалт хийгдэж байгааг мэдэхгүй байна. 55-64 настай 4 хүн тутмын 3 нь мэдэхгүй байна.


График 2: ХХЗХ-ны зохицуулалтын талаар мэддэг эсэх, насны бүлгээр



Эх үүсвэр: Асуулт 3.7

10 хүн тутмын 6 нь хувийн мэдээллээ хамгаалах анхан шатны тохиргоог мэдэхгүй байна. Ялангуяа 45-54 насны иргэдийн 84.6%, 55-64 насны иргэдийн 86.9% нь хувийн мэдээллээ хамгаалах Фейсбүүк, Инстаграм зэрэг сошиал орчинд пост оруулахдаа Паблик/Прайвит (Public/Private) тохиргооны ялгааг мэдэхгүй байна.


График 3: Public/private тохиргооны талаарх иргэдийн мэдлэг, насны бүлгээр



Эх үүсвэр: Асуулт 3.4

Цахим сүлжээнд олон цагийг зарцуулснаас болж дараах эрүүл мэндийн эрсдэлүүд хамгийн их бий болно гэж иргэд үзэж байна. Нүдний хараа муудах, ядаргаанд орох, дархлаа муудах, гэр бүлийнхэнтэйгээ харилцаа муудах нь хамгийн том эрүүл мэндийн эрсдэлүүдэд тооцогдож байна.


График 4: Цахим орчны зохисгүй хэрэглээнээс үүдэх эрүүл мэндийн эрсдэлүүдийн тухай ойлголт



Эх үүсвэр: Асуулт 7.5

Интернэтийн зохистой хэрэглээний талаар иргэд харьцангуй эерэг хандлагатай байна. Тэд хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавих нь эцэг эхчүүдийн үүрэг гэж үздэг бөгөөд +18 сайт болон зохиогчийн эрхийн зөрчилтэй вэбсайтыг хаадаг зохицуулалтыг дэмжиж байна.

Зураг 13: Интернэтийн зохистой хэрэглээтэй холбоотой иргэдийн хандлага



Эх үүсвэр: Асуулт 4.1 - 4.11

Хүүхдүүд цахим орчныг зүй зохистой хэрэглэж байгаа эсэхэд эцэг эхчүүд хяналт тавьж чаддаг гэдэгтэй иргэдийн 24.7% нь санал нийлэхгүй байна. Бага насны хүүхэдтэй байх боломжтой 35-44 насны иргэдийн 3 хүн тутмын 1 нь үүнтэй санал нийлэхгүй байна.


График 5: Эцэг эхчүүд цахим орчинд хүүхдүүддээ хяналт тавьж чаддаг эсэх, насны бүлгээр



Эх үүсвэр: Асуулт 4.3

Харин эцэг, эхчүүд нь хүүхдүүдээсээ илүү социал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал болж байна гэдэгтэй 10 хүн тутмын 9 нь санал нэгдэж байна. Хөдөө алслагдмал байршилд амьдрах тусам үүнтэй санал нийлэх нь багасаж байна.

График 6: Эцэг эхчүүд хүүхдүүдээсээ илүү социал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал эсэх, байршлаар




Эх үүсвэр: Асуулт 4.5

Цахим орчны хэрэглээтэй холбоотой иргэдийн хандлагыг бүлэглэж авч үзвэл, эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдийг бодвол буруу хандлагатай байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд цахим орчинд нууц үг үүсгэхдээ зөвхөн тоо эсвэл тэмдэгт ашиглах нь өөрт эргэн санахад амар байдаг гэдэгтэй илүү санал нийлж байна. Эмэгтэйчүүдийн хувьд иргэд интернэт орчинд соёлтой байж чаддаггүй, хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавих нь эцэг, эхчүүдийн үүрэг гэдэгтэй харьцангуй илүү санал нийлэх хандлагатай байна.

Интернэтийн хэрэглээтэй холбоотой сөрөг хандлагууд мөн зарим талаар илэрч байна. 10 хүн тутмын 9 нь цахим орчинд нууц үг үүсгэхдээ аль болох өөрт эргэн санахад хялбар зөвхөн тоо эсвэл тэмдэгт ашиглах нь амар гэдэгтэй санал нийлж байна. Мөн 84.2% нь төлбөртэй программ хангамжийг үнэгүй ашиглах боломж байхад заавал худалдаж авах шаардлагагүй гэж үзэж байна.


Зураг 14: Интернэтийн хэрэглээний талаарх сөрөг хандлага



Иргэд 10 хүн тутмын 8 нь сошиал орчинд бусад хүмүүс ихэвчлэн сөрөг мэдээллийг хуваалцдаг гэж үзэж байна. 4 хүн тутмын 3 нь иргэд сошиал орчинд соёлтой байж чаддаггүй гэж үзэж байна.

Тэдний 75.2% нь интернэт орчинд иргэд соёлтой байж чаддаггүй гэдэгтэй санал нийлж байна. Насны бүлгээр нь харахад 55-64 настай 4 хүн тутмын 3 нь иргэд интернэт орчинд соёлтой байж чаддаггүй гэж үзжээ. Харин 18-24 настай залуу үеийн төлөөллийн 4.1% нь үүнтэй санал нийлэхгүй байна. Иргэдийн боловсролын түвшнээр харьцуулж үзвэл боловсролын түвшин өндөр болох тусам иргэд интернэт орчинд соёлтой байж чаддаггүй гэдэгтэй илүү санал нийлж байна.


График 7: Иргэд интернэт орчинд соёлтой байж чаддаггүй гэдэгтэй санал нийлэх хувь, насны бүлгээр



Эх үүсвэр: Асуулт 4.11

Цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд хийж болох үйлдлүүдийг иргэдээс тодруулахад 4 хүн тутмын нэг нь цахим хаягийн нууц үгээ тогтмол солих, 5 хүн тутмын нэг нь танихгүй хүмүүстэй найз болохгүй байх, 15.0% нь хувийн мэдээллээ цахим орчинд оруулахгүй хамгаалах, 11.2% нь үнэн эсэх нь тодорхойгүй мэдээлэл авч цааш түгээхгүй байх зэргийг дурджээ. Харин иргэдийн 13.5% нь ямар аргаар цахим орчинд өөрийгөө хамгаалж болох талаар мэдэхгүй гэсэн байна.


График 8: Цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд хийж болох үйлдлүүд



Эх үүсвэр: Асуулт 7.3

Судалгаагаар хувийн мэдээллээ алдсанаар ямар эрсдэл үүсэж болохыг тодруулахад иргэдийн 32.4% нь хувийн мэдээллээ алдсанаар ямар асуудал үүсэж болохыг хэлж мэдэхгүй байна. 10 хүн тутмын 7 нь хувийн мэдээллээ алдах нь ямар нэг эрсдэлтэй гэж мэдэж байгаагаас мөнгө санхүүгээр хохирох, залилан гэмт хэрэгт өртөх, нэр хүндээ алдах, хувийн нууцаа алдаж сүрдүүлэг, дарамтад өртөх зэрэг асуудлуудыг үүсгэнэ гэж үзэж байна.

График 9: Хувийн мэдээллээ алдсанаар үүсэж болох эрсдэлийн талаарх иргэдийн ойлголт



Эх үүсвэр: Асуулт 6.2

Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд хэрэглэгчдэдээ интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдээ мэдээллийг хүргэх байдал харилцан адилгүй байна.

Монгол улсын хэмжээнд хамрах хүрээ өргөн, томоохон интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд интернэтийн үйлчилгээг хүргэх технологийн аюулгүй байдалд анхаарч, олон улсын стандарт шаардлага, мэдээллийн аюулгүй байдлын бодлого журмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дэлхийн шилдэг дэвшилтэт техник технологийг хэрэглэгчдэдээ хүргэхийг эрмэлзэн ажилладаг байна. Харин орон нутгийн хамрах хүрээ багатай ИҮҮ-ийн хувьд тэр бүр сайн технологийг нэвтрүүлэх боломжгүй, бусад томоохон компанийн шилэн кабелийн сүлжээг түрээслэх замаар интернэт үйлчилгээг үзүүлж байна.

Хэрэглэгчдэдээ интернэт гэж яг юу юм, ямар ямар шалтгаанаас болоод зарим тохиолдолд уддаг юм, интернэтийн хурдад нөлөөлдөг зүйл нь юу байдаг, цахим орчинд идэвхтэй харилцаж байгаа тохиолдолд өөрийн мэдээллээ аюулгүй байлгах үүднээс ямар суурь алхмуудыг хийж, ямар мэдээллүүдтэй байх ёстой юм гэх мэт мэдээллийг хүргэж байгаа. Хэрэглэгч өөрөө хүссэн тохиолдолд, хүссэн үедээ мэдээллийн аюулгүй байдал болон интернэт үйлчилгээний чанартай холбоотой мэдээллүүдийг авах сувгуудыг нээж өгсөн.

ИҮҮ байгууллага - 1

Томоохон ИҮҮ-ийн хувьд интернэтийн талаарх ерөнхий ойлголт мэдлэгийг иргэдэд нээлттэй байлгах мэдээллийн сан үүсгэх, богино хугацааны аян арга хэмжээ зохион байгуулах, видео контент бүтээх зэрэг ажлуудыг хийж байсан байна. Интернэттэй холбоотой мэдлэг мэдээлэл олгохдоо тэд ихэвчлэн өөрсдийн сошиал медиа платформуудад хаштаг үүсгэн, мэдээлэл түгээдэг байна.

IPS систем, интернэтийн үндсэн сүлжээн дээр хамгаалж болох хамгийн боломжтой, хамгийн сүүлийн үеийн ололт амжилт болсон технологиудыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалт хийж, хэрэглэгчдээ хамгаалж байдаг. Мэдлэг мэдээллийг нь сайжруулах зорилгоор ийм төрлийн халдлага яваад байна, ингэж сэргийлэх сүлжээний тохиргоо хийгээрэй гэж хэлдэг. Иргэдэд мэдээлэл хүргэхдээ веб хуудас болон борлуур, сурталчилгааны материал дээрээ тусгаж өгдөг. Мөн НҮБ, Faro foundation зэрэг байгууллагуудын нөлөөллийн арга хэмжээ аянд хамтран оролцдог. Телевизээр бол уламжлалт мэдээ тал руугаа ордог, хэвлэмэл материалаар нууц үг хэрхэн солих зэргийг хүргэвэл хэрэглэгчид авч хадгалаад, хэрэгтэй үедээ хэрэглэнэ. НҮБ-тай хамтарч гаргасан гарын авлага их зүгээр санагдаж байсан.

ИҮҮ байгууллага - 2

Тоон гарын үсгийн талаар 10 хүн тутмын 6 нь сонсож байгаагүй байна. Тоон гарын үсгийн талаар сонсож байсан иргэд тоон гарын үсгийг яг юу болохыг нь сайн мэдэхгүй эсвэл ихэвчлэн онлайн гарын үсэг, нууц код, тоогоор илэрхийлсэн гарын үсэг гэж ойлгож байна.

Зураг 15: Тоон гарын үсгийн талаарх иргэдийн ойлголт

Хувь хүний мэдээлэл
 Дахин давтагдашгүй код, дугаар
 Намайг илэрхийлэх мэдээлэл, баталгаа
 Гарын үсгийг орлох зүйл
МЭДЭХГҮЙ^{РД}
 Онлайн гарын үсэг^{Бар код}
 Код Тоо Нууцлал Баталгаат гарын үсэг
^{Хурууны хээ} Санхүүд хэрэглэгддэг код
 ААН-д хэрэглэгддэг гарын үсэг
 Баталгаажуулах код


Эх үүсвэр: Асуулт 7.1, 7.2

4.3 Судалгаанд хамрагдсан иргэдийн интернэт хэрэглээ

Бүлгийн дүгнэлт:


- Интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн санаа бодлын суурь **судалгаанд хамрагдсан 18-64 насны иргэдийн 98.5% нь гар утсаараа интернэт ордог, ихэвчлэн 1-2 төрлийн төхөөрөмжийг ашиглан** интернэтэд холбогдож байна. Тэдний 63.4% нь зөвхөн гар утсаараа интернэтэд холбогддог байна.
- **10 хүн тутмын 7 нь мэдээ, мэдээлэл авах зорилгоор** интернэтэд орж, **2 хүн тутмын 1 нь интернэтээр дамжуулан төлбөр тооцоо** хийж байна.
- Иргэд нэг өдөрт дунджаар 7.2 цагийг интернэт орчинд идэвхтэй өнгөрүүлж байна.

График 10: Интернэтэд орохдоо ашигладаг төхөөрөмж



Иргэдийн 27.0% нь өөрийн төхөөрөмждөө ямар нэг байдлаар вирусийн хамгаалалт, firewall, хатуу диск зэргийг хэрэглэж байгаа бол 42.6% нь хамгаалалтгүй, 30.5% нь хамгаалалт байгаа эсэхийг мэдэхгүй байна. Интернэтэд холбогдохдоо ашигладаг сүлжээний хувьд **гар утасны мобайл дата 10 хүн тутмын 8 нь ашигладаг** бол 44.6% нь өөрийн болон найз нөхдийнхөө гэрийн Wifi сүлжээг ашигладаг байна. Гэр хорооллын иргэдийн 86.5% нь мобайл дата ашигладаг бол орон сууцны хорооллын 63.4% нь гэрийн Wifi сүлжээг ашиглаж байна.


График 11: Интернэтэд холбогддог сүлжээний төрөл



Эх үүсвэр: Асуулт 2.4

Иргэдийн 78.1% нь Facebook ашиглахын тулд интернэт орж байна. 10 хүн тутмын 7 нь мэдээ, мэдээлэл авах зорилгоор интернэтэд орж, 2 хүн тутмын 1 нь интернэтээр дамжуулан төлбөр тооцоо хийж байна. Эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүд интернэтэд ороходоо бараа бүтээгдэхүүн онлайнар худалдан авч байгаа бөгөөд е-баримтыг идэвхтэйгээр бүртгүүлж байна. Харин эрэгтэйчүүд илүү кино үзэж, тоглоом тоглодог байна.

График 12: Интернэт ашиглаж буй зорилго



Эх үүсвэр: Асуулт 2.2

Монгол Улсын 18-64 насны иргэд нэг өдөрт дунджаар 433 минутыг интернэт орчинд идэвхтэй өнгөрүүлж байна. Үүнээс 141 минутыг ажил эсвэл хичээлээ хийх, 120 минутыг сошиал медиа ашиглах, 118 минутыг тоглоом тоглох, 62 минутыг дуу видео үзэх зэрэг энтертайнмент зорилгоор ашиглаж байна.

График 13: Нэг өдөрт интернэт хэрэглэж байгаа дундаж хугацаа, минутаар





График 14: Нэг өдөрт интернэтэд зарцуулж буй хугацаа, минутаар



Эх үүсвэр: Асуулт 2.3

Иргэд нэг өдрийнхөө дунджаар гуравны нэг хугацааг интернэт орчинд өнгөрүүлж байна. Энэ нь сард 9 өдөр, жилд 3 сар 18 хоног орчим хугацаа гэсэн үг юм. Тэд зөвхөн хувийн зорилгоор бус ажил, хичээлээ хийхдээ интернэтийг идэвхтэйгээр ашиглаж байна. Сошиал медиа хэрэглээ ч мөн дэлхийн трендийг даган хурдацтайгаар нэмэгдэж байна. Нэг өдөрт бараг 2 цаг орчим интернэтээр тоглоом тоглож байгаа нь анхаарал татаж байна.

4.4 Иргэдийн өдөр тутмын интернэтийн хэрэглээ


Бүлгийн дүгнэлт:

- Иргэдийн интернэтийн орчин дахь эерэг хэрэглээтэй холбоотой үзүүлэлт дээр өндөр байгаа хэдий ч тухайн эерэг зан үйлийг тогтмол хийдэг байдал бага байна. **Өөрийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавихыг 85% нь хичээдэг** хэдий ч ердөө 15% нь тогтмол тодорхой хэмжээгээр цахим хэрэглээндээ хязгаар тавьдаг байна. Гар утас, болон төхөөрөмжийн системийн шинэчлэлийг 70% нь хийхийг хичээдэг хэдий ч **19% нь тогтмол шинэчлэлээ хийдэг** байна.
- Интернэт, сошиал, гар утасны хэт их хэрэглээ маш их байгаа нь хоол идэж байхдаа интернэт ашигладаг байдал, болон өглөө босоод л шууд сошиал хаягаа шалгадаг байдал 49% дээш байгаагаас харагдаж байна. Мөн уг **хэт их хэрэглээнээс үүдэн нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал 10 хүн тутмын 8-д нь тулгамдаж байсан** байна.
- Цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудал дээр иргэдийн хувьд **560 мянган хүн сошиал орчинд байршуулсан өөрийн болон ойр зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авч байсан** байна. 5 хүн тутмын 1 нь сошиал медиа, имэйл хаягаа ямар нэгэн байдлаар өөрөө болон бусдыг хакердуулж байсан тохиолдол өөрт нь болон ойр дотны нэгэнд нь тулгарч байсан байна. Өөрийг нь айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас танихгүй хүнээс авч байсан тохиолдол нийт иргэдийн 17 хувь нь тохиолдож байсан байна.
- **Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ** та эсвэл таны эргэн тойрны хүн ямар үйлдэл хийснийг нь тодруулахад **39% нь цагдаагийн байгууллагад мэдэгдсэн**, 19% нь ямар нэгэн үйлдэл хийгээгүй, 12% нь ямар үйлдэл хийх ёстойгоо мэдэхгүй байна.

Иргэдийн интернэт орчин дахь эерэг болон сөрөг зан үйлийг тодруулахдаа нийт 10 үзүүлэлтийн хүрээнд тодруулсан. Эерэг зан үйлийн хувьд нийт иргэдийн 85% нь өөрийнхөө цахим хэрэглээнд хязгаарлалт тавихыг хичээдэг, 82% нь сошиал болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп нууц үгээ өөр байлгахыг хичээдэг, 72% нь гар утас, компьютерын шинэчлэлээ хийхийг хичээдэг, 51% нь интернэтийн орчин дах мэдээллийн үнэн бодит эсэхийг шалгадаг бол 38% нь цахим хаяг дах нууц үгээ 6 сар тутам солихыг хичээдэг боловч 9% нь тогтмол сольдог байна.

Харин сөрөг зан үйлийн хувьд нийт иргэдийн 79% -д нь гар утас бусад төхөөрөмжийн хэт их хэрэглээнээс үүдэн нүд улайх, нойргүйдэх асуудал тулгарч, 62% нь өглөө босоод л шууд сошиал хаягаа шалгаж, 54% нь зохиогчийн эрхтэй контентыг интернэтээр үнэгүй үзэж байсан байна.

Зураг 16: Интернэтийн орчин дахь хэрэглээ



Эх үүсвэр: Асуулт 5.1-5.10

Өөрийн цахим орчны хэрэглээндээ 18-24 насны залуучуудын 94% нь хяналт тавихыг хичээдэг бөгөөд үүнээс 20% нь цахим орчны хэрэглээндээ байнга хязгаар тавьдаг байна. Харин хүйсийн хувьд цахим орчны хэрэглээндээ хязгаар тавьдаг байдал дээр ялгаа бага байна.


График 15: Өөрийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг байдал, нас хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.8

Сошиал хаяг болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп-уудаа 55-64 насны иргэдийн 63% нь нэг ижил нууц ашиглаж байна. Харин 18-24 насны залуучуудын 49% нь сошиал хаяг болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп-ууддаа өөр өөр нууц үг ашиглаж цахим аюулгүй байдлаа нэмэгдүүлдэг байна.


График 16: Сошиал хаяг болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп-уудын (банкны апп зэрэг) нууц үг өөр өөр байдаг иргэдийн хувь, нас хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.10


Гар утас суурийн компьютерын программаа 18-24 насны залуучуудын 94% нь хийхийг хичээдэг бөгөөд 36% нь тогтмол шинэчлэлээ хийдэг байна. Харин 55-64 насны иргэдийн ердөө 5% нь тогтмол гар утас болон суурийн компьютерын шинэчлэлээ хийдэг байна.

График 17: Төхөөрөмжийн программаа шинэчилдэг иргэдийн хувь



Интернэт орчинд байгаа мэдээлэл хуурамч эсэхийг 55-64 насны иргэдийн 5% нь мэдээллийн эх үүсвэрийг байнга шалгаж хардаг байна. Харин 18-24 насны залуучуудын 23% нь тухайн мэдээлэл үнэхээр үнэн эсэхийг нягталж хардаг бол 13% нь огт нягталдаггүй байна.

График 18: Интернет орчинд байгаа мэдээлэл хуурамч эсэхийг болон мэдээллийн эх үүсвэрийг шалгаж үздэг иргэдийн хувь, нас, хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.2

Цахим хаягийн нууц үгнүүдээ 55-64 насны иргэдийн 83% нь огт шинэчилж сольдоггүй бол 25-34 насны иргэдийн 13% 6 сар тутам тогтмол сольдог байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд 63% нь нууц үгээ шинэчлэн сольдоггүй байна.


График 19: Цахим хаягийн нууц үгнүүдээ 6 сар тутам сольдог иргэдийн хувь, нас хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.9

Гар утас болон бусад төхөөрөмжийн хэрэглээнээс болж 18-24 насны залуусын 87 хувьд нь нүд улайх, нойргүйдэх асуудал бусад насны бүлэгтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь гар утас болон төхөөрөмжийн хэрэглээ энэ бүлэгт хэт их байгааг харуулж байна. Харин 45-64 насны бүлэгт уг асуудал бусад бүлэгтэй харьцуулахад бага хэдий ч уг бүлгийн 10 иргэн тутмын 7-д нь нүд улайх, нойргүйдэх асуудал гардаг байна. Мөн эмэгтэйчүүдийн 82 хувьд нь гар утасны хэрэглээнээс үүдэн 82 хувьд нь нүд улайх, нойргүйдэх асуудал гарч байсан байна.


График 20: Гар утас, бусад төхөөрөмжийн хэт их хэрэглээнээс болоод нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал тулгардаг иргэдийн хувь, нас хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.1

18-44 насны иргэдийн 60% дээш хувь нь өглөө босоод л шууд сошиал хаягаа шалгаж байсан байна. Энэ нь сошиал хэрэглээндээ маш их цаг зарцуулж байгааг харуулж байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд өглөө босоод л шууд сошиал хаягаа шалгадаг байдал эрэгтэйчүүдээс 7%-р илүү байна.


График 21: Өглөө босоод шууд сошиал хаягаа хамгийн түрүүнд шалгадаг иргэдийн хувь



Эх үүсвэр: Асуулт 5.6

Зохиогчийн эрх бүхий кино, драма зэрэг контентыг иргэдийн 54% нь интернэтээс үнэ төлбөргүй үзэж байсан бөгөөд ялангуяа 18-24 насны залуучуудын 68% төлбөртэй контентыг үнэгүй үзэж байсан байна. Илүү залуу насны бүлэгт төлбөртэй контентыг үнэгүй үзэх хандлага өндөр байна.


График 22: Кино, драма зэрэг зохиогчийн эрхтэй контентыг интернэтээр үнэгүй үздэг



Эх үүсвэр: Асуулт 5.5

Эрэгтэйчүүдийн 5% нь хоол идэж байхдаа давхар интернэт байнга ашиглаж байдаг бол эмэгтэйчүүдийн хувьд 3% хоол идэж байхдаа давхар интернэт ашигладаг байна. 18-24 насны бүлэгт хоол идэж байхдаа байнга интернэт ашигладаг байдал 45-54 насны бүлэгтэй харьцуулахад 8 дахин өндөр байна.


График 23: Хоол идэж байхдаа интернэт ашигладаг иргэдийн хувь



Эх үүсвэр: Асуулт 5.7

Эрэгтэйчүүдийн хувьд төлбөртэй программ хангамж, тоглоомыг үнэггүй татаж авч байсан байдал эмэгтэйчүүдээс 13%-р илүү байна. Харин 18-24 насны залуучуудын 5% нь төлбөртэй программ, тоглоомыг байнга үнэгүй байдлаар татаж авч ашигладаг байна.

График 24: Төлбөртэй программ, тоглоомыг интернэтээс үнэгүй татаж авч байсан, нас хүйсээр



Эх үүсвэр: Асуулт 5.8

4.5 Иргэдийн мэдлэг, хандлага, туршлага хоорондын хамаарал

Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага, туршлагын хоорондын хамаарлыг тогтоохын тулд байгаа хувьсагчийг шууд ашиглан болон шинээр хувьсагч үүсгэн хүчин зүйлсийн шинжилгээг хийлээ.

Интернэтийн зохистой хэрэглээ болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг (Knowledge index), түүнд хандах хандлага (Attitude index), интернэттэй холбоотой үйлдэл (Practice index)-ийн хоорондох болон бусад хүн ам зүйн үзүүлэлт хоорондын хамаарлын шинжилгээг *BIVARIATE Pearson's correlation* –ийн аргыг ашиглан хийлээ.

Иргэдийн мэдлэгийн түвшнийг хүн ам зүйн үзүүлэлттэй нь харьцуулахад дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийж болж байна.

- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол энэ талаар илүү мэдлэгтэй байна. Нас болон мэдлэгийн түвшин хоорондоо урвуу хамааралтай байна. (корреляцийн коэффициент [-0.322], ач холбогдлын түвшин (0.000)). Иргэдийн нас 10-аар нэмэгдэхэд мэдлэгийн түвшин 43.6%-аар буурч байна.
- Харин боловсролын түвшин нэмэгдэх тусам мэдлэгийн түвшинд эергээр нөлөөлж байгаа бол хотын иргэд хөдөөгийн иргэдтэй харьцуулахад мэдлэг сайн байна.

Иргэдийн мэдлэг болон хандлага хоорондоо мөн эерэг хамааралтай байна.

- **Интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг болон интернэтэд хандах хандлага хоёрын хооронд эерэг хамааралтай байна** (корреляцийн коэффициент [0.247], ач холбогдлын түвшин (0.000)).
- **Зөв хандлагатай байгаа иргэд интернэтийг зохистой хэрэглэж байна.** ([0.242],(0.000)).


Интернэтийг зохистой хэрэглэж байгаа байдлыг тухайн хүн ам зүйн үзүүлэлттэй нь хамааралтай эсэхийг ач холбогдлын түвшнээр нь авч үзэхэд дараах гол дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

1. **Насны бүлэг.** Иргэдийн нас 10 насаар нэмэгдэхэд нэг өдөрт интернэт хэрэглэх дундаж хугацаа 29.1 хувиар буурч байна.
2. **Боловсролын түвшин.** Мэдлэгийн түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд интернэтийг зохистой хэрэглэх магадлал 16.9%-аар нэмэгдэж байна.
3. **Хандлага.** Интернэт хэрэглээний талаар зөв хандлагатай байх тусмаа интернэтийг зохистой хэрэглэх магадлал өндөр байна. ([0.211],(0.000))

4.6 Иргэдийн цахим гэмт хэрэгт өртсөн байдал

Цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудал дээр иргэдийн хувьд 560 мянган хүн социал орчинд байршуулсан өөрийн болон ойр зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авч байсан байна. 5 хүн тутмын 1 нь социал медиа, имэйл хаягаа ямар нэгэн байдлаар өөрөө болон бусдыг хакердуулж байсан тохиолдол өөрт нь болон ойр дотны нэгэнд нь тулгарч байсан байна. Өөрийг нь айлган сүрдүүлсэн, занал хийлсэн утга бүхий зурвас танихгүй хүнээс авч байсан тохиолдол нийт иргэдийн 17.5 хувь нь тохиолдож байсан байна.


График 25: Цахим гэмт хэрэгт өөрөө болон ойр дотны хэн нэг нь өртсөн байдал (Эх олонлогт тархаасан байдлаар)



Эх үүсвэр: Асуулт 6.3

Цахим гэмт хэргийн хувьд 18-24 насныхан илүү өртсөн хандлага өндөр байна. Ялангуяа социал орчинд оруулсан мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авах, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас хүлээж авч байсан байдал зэрэг үзүүлэлт дээр илүү өрсөн хандлага өндөр байна. 18-34 насны залуусын 19% нь өөрөө болон ойр дотны хэн нэгэн нь онлайн худалдааны луйварт өртөж хохирч байсан байна.

График 26: Цахим гэмт хэрэгт өөрөө болон ойр дотны хэн нэгэн өртсөн байдал, насны бүлгээр



Эх үүсвэр: Асуулт 6.3

Хэрэв цахим гэмт хэрэгт өрвөл 84% цагдаагийн байгууллагад хандана гэж үзэж байгаа бол 8% нь интернэтээс мэдээлэл хайх эсвэл, найз нөхдөөсөө тусламж авна гэж үзэж байна. Мөн 8% нь холбогдох хууль хүчний байгууллагад хандана гэж үзэж байна.


Зураг 17: Цахим гэмт хэрэгт өрвөл хандах байгууллага



Эх үүсвэр: Асуулт 6.4

Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ та эсвэл таны эргэн тойрны хүн ямар үйлдэл хийснийг нь тодруулахад 39% нь цагдаагийн байгууллагад мэдэгдсэн, 19% нь ямар нэгэн үйлдэл хийгээгүй, 12% нь ямар үйлдэл хийх ёстойгоо мэдэхгүй байна гэж хариулжээ.


Зураг 18: Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ өөрөө болон ойр дотны хэн нэгний хийсэн үйлдэл



Эх үүсвэр: Асуулт 6.5

Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ 18-24 насны иргэдийн 42% нь цагдаагийн байгууллагад хандаж байсан бол 14% нь тухайн цахим гэмт хэргийн талаар холбогдох байгууллагад хандаагүй байна. Харин эмэгтэйчүүдийн 45% нь цахим гэмт хэрэгт өртсөн талаараа цагдаагийн байгууллагад хандсан байна.

График 27: Цахим гэмт хэрэгт өртсөн үедээ өөрөө болон ойр дотны хэн нэгний хийсэн үйлдэл




Хүмүүс надад нэг их алдаад байх зүйл байхгүй, имэйл хаяг, фэйсбүүк дээр юу ч байхгүй гээд байдаг. Тэгээд нэг найдаж фэйсбүүкээрээ дамжуулан мөнгөө алдах, өөр данс руу мөнгө шилжүүлээд хохирогч болсныхоо дараа ойлгодог.

ИҮҮ байгууллагын төлөөлөл

4.7 Иргэдийн мэдээ, мэдээлэл авсан байдал ба хүлээн авахыг хүсэж буй хэрэгсэл, хэлбэр

Иргэдийн 24.0% нь цахим орчны ёс зүй, зохистой хэрэглээг сурталчлан таниулсан, цахим орчинд хэрхэн хамгаалах, нийгмийн сүлжээний эерэг болон сөрөг талуудын талаарх мэдээллийг хүлээн авч байсан байна.

График 28: Цахим орчны зохистой хэрэглээ, аюулгүй байдлын талаар мэдээ мэдээлэл авч байсан эсэх



Эх үүсвэр: Асуулт 7.6

Иргэдээс интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдээ мэдээллийг авахыг хүсэж буй мэдээллийн хэрэгслийг тодруулахад 10 хүн тутмын 6 нь орон даяар цацагддаг өргөн нэвтрүүлгийн телевизээр мэдээлэл авахыг хүсэж байна. Мөн gogo.mn, ikon.mn гэх мэт цахим мэдээ, мэдээллийн вэбсайт, цагдаагийн байгууллагаас мэдээллийг авах сонирхолтой байна.

Хүснэгт 8: Мэдээ мэдээлэл авахыг хүсэж буй мэдээллийн хэрэгсэл, байршил, насны бүлгээр

	Нийт	Байршил		Насны бүлэг				
		Хот	Хөдөө	18-24	25-34	35-44	45-54	55-64
Өргөн нэвтрүүлгийн телевиз	61.6%	63.2%	59.5%	56.3%	61.2%	62.2%	63.0%	66.3%
Цахим мэдээ, мэдээллийн вэбсайтаас	57.6%	64.9%	48.0%	69.8%	63.3%	51.0%	52.6%	48.8%
Цагдаагийн байгууллагаас	48.3%	47.5%	49.3%	54.0%	46.8%	48.4%	49.3%	42.3%
e-mongolia	45.2%	50.8%	37.9%	57.1%	47.7%	41.9%	41.2%	36.2%
Найз нөхдөөсөө	39.4%	37.3%	42.2%	45.7%	37.1%	40.0%	35.9%	40.4%
Сум, дүүргийн ФБ хуудаснаас	33.9%	28.0%	41.8%	24.5%	35.1%	38.5%	35.7%	32.2%
Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч	32.4%	35.8%	27.9%	29.6%	35.5%	39.1%	27.9%	22.5%
Баг, хорооны иргэдийн ФБ группээс	31.1%	29.0%	33.8%	20.3%	33.8%	28.5%	38.7%	32.7%

	Нийт	Байршил		Насны бүлэг				
		Хот	Хөдөө	18-24	25-34	35-44	45-54	55-64
Ном сэтгүүл, хэвлэмэл материалаас	30.0%	32.5%	26.5%	33.6%	26.3%	28.0%	31.8%	34.6%
Тусгайлсан вэбсайтаас	26.8%	31.7%	20.3%	33.3%	28.3%	22.3%	21.4%	31.2%
Орон нутгийн телевизээс	25.7%	19.8%	33.7%	22.2%	18.0%	31.3%	30.2%	30.9%
Фм, радиогоос	20.7%	23.3%	17.2%	18.3%	23.4%	19.2%	18.6%	23.5%
Сум, дүүргийн ЗДТГ-ын мэдээллийн самбараас	13.1%	8.1%	19.7%	11.9%	11.9%	13.6%	15.6%	12.8%
Баг, хорооны байрны мэдээллийн самбараас	12.0%	10.7%	13.8%	4.2%	10.2%	17.7%	13.9%	12.8%
Сум, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан	10.3%	7.9%	13.6%	13.1%	10.5%	9.4%	10.4%	7.9%
Иргэдийн нийтийн хурлаас	8.0%	6.5%	10.1%	2.6%	8.0%	7.2%	11.7%	11.4%

Эх үүсвэр: Асуулт 7.7

Мэдээ, мэдээллээ хүлээн авах хэлбэрийн хувьд видео хэлбэрээр болон телевизийн контент хэлбэрийг илүүд үзэж байна. 18-24 насны залуучууд видео болон подкаст хэлбэрийг илүүд үзэж байгаа бол 55-64 насны иргэд видео телевизийн контент болон хэвлэмэл материалаар мэдээ мэдээлэл авах сонирхолтой байна.

Хүснэгт 9: Мэдээ мэдээлэл авахыг хүсэж буй хэлбэр, хот хөдөөгөөр, насны бүлгээр

	Нийт	Байршил		Насны бүлэг				
		Хот	Хөдөө	18-24	25-34	35-44	45-54	55-64
Видео хэлбэрээр	57.1%	60.1%	53.2%	61.2%	62.2%	56.9%	47.6%	54.7%
Телевизийн контент	46.5%	46.4%	46.5%	35.5%	45.4%	47.6%	52.3%	52.7%
Мессежээр	37.5%	36.7%	38.6%	27.6%	36.2%	42.4%	40.1%	40.5%
Утсаар	34.9%	34.3%	35.8%	23.6%	36.1%	34.4%	40.3%	40.3%
ФБ постоор	32.7%	31.2%	34.7%	32.9%	35.3%	31.6%	35.0%	25.1%
Ном сэтгүүл, хэвлэмэл тараах материал	28.8%	27.4%	30.8%	26.2%	24.6%	26.6%	30.3%	44.0%
Подкастаар	23.1%	28.2%	16.4%	46.9%	23.5%	18.4%	16.4%	9.7%
Онлайн сургалтаар	20.8%	19.1%	22.9%	25.1%	16.5%	21.3%	22.9%	20.8%
ФБ сторигоор	11.2%	10.7%	11.8%	12.6%	15.3%	11.7%	6.2%	6.2%
Бүлгийн сургалтаар	6.1%	4.5%	8.2%	6.8%	4.1%	7.9%	6.8%	5.2%
Бусад	1.1%	1.2%	1.1%	1.5%	0.7%	0.8%	2.1%	0.9%

Эх үүсвэр: Асуулт 7.8

Бид бүтээлч байдлаар янз бүрийн контент үүсгээд үйлдвэрлээд явдаг боловч хүссэн хэмжээнд хүрдэггүй. Хэрэглэгчдийн интернэтийн зөв зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлд зөвхөн ИҮҮ гэлтгүй, төрийн байгууллага бүх төвшиндөө хамтарч хүргэвэл үр дүнтэй санагддаг.

ИҮҮ байгууллагын төлөөлөл

4.8 Цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, зохион байгуулалт

Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, улмаар зөв зан үйлийг амьдралын өдөр тутмын дадал хэвшил болгон хэвшүүлэхийн

Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ИҮҮ) компаниуд өөрсдөө хэрэглэгчдийн боловсролд чиглэсэн контентүүдийг бэлтгэн хүргэхэд хандалт багатай, иргэд буруугаар хүлээж авах хандлага ажиглагддаг. Иргэдийн интернэтийн зөв зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлд бол холбогдох төрийн байгууллага бүх төвшиндөө хамтарч, өргөн цар хүрээнд төрөл бүрийн мэдээллийн сувгаар дамжуулан энэ мэдээллийг хүргэснээр иргэд хэрэглэгчид маань зөв бодолтой болно.

ИҮҮ байгууллагын төлөөлөл

тулд дараах үндсэн хэсгүүдээс бүрдэх мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг цогцоор нь зохион байгуулахыг суурь судалгааны үр дүнд үндэслэн санал болгож байна.

Хүснэгт 10: Мэдээлэл харилцааны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө

<i>Зорилго:</i>	Интернэт хэрэглэж байгаа насанд хүрсэн иргэдийн өдөр тутмын зан үйлд интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангасан үйлдлүүдийг хэвшүүлэх		
<i>Хүлээн авагч:</i>	18-24 насныхан	25-45 насныхан	45+ насныхан
<i>Зорилт:</i>	Цахим орчны хэрэглээг эрүүл мэндэд ээлтэй зохистой байлгах, хэрэглээгээ хянадаг болгоход уриалах	Цахим орчинд үүсэж болох эрсдэлүүдийг жишээгээр тайлбарлах, эцэг, эхийн хяналт хэрхэн хийж болохыг сурталчлах, гэр бүлийн зөв соёлтой хэрэглээнд уриалах	Цахим орчинд аюулгүй байдлаа хангах анхан шатны тохиргоонуудыг зааж өгөх, хэрэглэж хэвшүүлэх
<i>Гол мессеж:</i>	Цахим орчинд соёлтой байцгаая	Интернэтийг зохистой хэрэглэе	Интернэт суръя
<i>Мэдээлэл хүргэх суваг</i>	Цахим сайт E-Mongolia Орон даяарх ТВ Цагдаа	Цахим сайт Орон даяарх ТВ E-Mongolia Цагдаа	Орон даяарх ТВ Цахим сайт Цагдаа Найз нөхөд
<i>Мэдээлэл хүргэх хэлбэр:</i>	Видео Подкаст ТВ контент ФБ пост	Видео, ТВ контент Мессеж Утсаар ФБ пост	Видео, ТВ контент Ном, сэтгүүл, хэвлэмэл материал Мессеж Утас
<i>Хамтран ажиллах байгууллагууд:</i>	<ul style="list-style-type: none"> • Цахим мэдээ мэдээллийн сайтууд • Өргөн нэвтрүүлгийн телевизүүд • E-Mongolia цахим хуудас • Цагдаагийн байгууллага • Утасны оператор компаниуд • Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд • Цахим үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд • Фэйсбүүк зэрэг томоохон платформууд • Банкууд 		

Мөн дараах боломжит ивээн тэтгэгч, шат шатны байгууллагуудтай хамтран, үндэсний хэмжээнд нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

- Боловсролын салбарынхан
- Бизнесийн топ компаниуд, хувийн хэвшил
- Хөтөлбөрийн менежерүүд
- Хэвлэл мэдээллийн салбарынхан
- Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүд
- Мэргэжлийн холбоод
- Иргэний нийгмийн байгууллагууд
- Банк, санхүүгийн цахим үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
- Сошиал медиа платформууд

Бүгд дэмжих боломжтой нэгдсэн нэг уриалга гарган, албан байгууллага болон иргэдийг сайн дурын үндсэн дээр уриалах, мэдээлэл хүргэх боломжтой дээр дурдагдсан хүртээмжтэй сувгаар нэгэн зэрэг мэдээлэл харилцааны үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Уриалга нь аль болох тодорхой, энгийн зүй зохистой үйлдэлд хөтөлсөн байвал тохиромжтой бөгөөд жишээ нь дараах утгатай байж болно. Тодорхой насны бүлгээр мэдээлэл харилцааны үйл ажиллагааны агуулга нь ялгаатай байх нь оновчтой байна.

Хүснэгт 11: Иргэдэд хүргэх мэдээлэл харилцааны агуулга, хэлбэр, зорилтот бүлгээр

№	Зорилтот бүлэг	Мессеж	Агуулга
Интернэтийн зохистой хэрэглээтэй холбоотой асуудлууд			
1	18-24 насны хот, хөдөөгийн залуучууд	"Цагаа хяная- Өдөрт Фэйсбүүк 4 цагаас хэтрүүлэхгүй"	Эрүүл мэндийн эрсдэлийг ойлгуулах
2	18-35 насны хотын залуучууд	"Апп, программыг зөвхөн албан ёсны газраас нь татъя"	Төлбөртэй программыг үнэгүй татах нь ямар эрсдэл дагуулж болохыг ойлгуулах
3	18+ насны иргэд	"Интернэт орчинд соёлтой байя" "Интернэтэд зэрэг"	Өөртөө тохиолдохыг хүсэхгүй зүйлийг бусдад бүү хий. Бүдүүлэг үг хэллэг, бусдыг доромжилсон үйлдлийг хийхгүй байхад уриалах.
4	Оюутнууд	"Сошиал хаяг болон банкны нууц үгээ өөр өөр байлгая"	Нууц үгтээ тоо тэмдэгт, жижиг, том үсэг ашиглаж, банкны болон сошиал хаягийн нууц үгээ өөр өөр байлгахад уриалах
5	Бүх иргэд	"Өөр өөр нууц үг хэрэглэе"	Нууц үгээ алдвал учирч болох эрсдэлүүдийг таниулж, төрсөн өдөр, утасны дугаар зэргийг нууц үгтээ ашиглахгүй байхад уриалах
Мэдээллийн технологийн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд			
6	25-45 насны иргэд	"2 давхар хамгаалалт хэрэглэж хэвшье" – Two factor authentication	Мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, өөрийгөө хамгаалж болох энэ чухал энгийн аргыг сурталчлах
7	25+ насны иргэд	"Public/private тохиргоо заавал хийе"	Мэдэхгүй иргэдэд мэдэгдэж, хэрэглэж хэвшээгүй иргэдэд байнгын хэрэглээ болгохыг уриалах

№	Зорилтот бүлэг	Мессеж	Агуулга
8	18-аас дээш насны иргэд, албан байгууллагууд	"Бүх төхөөрөмжөө хамгаалья"	Мэдээллийн технологийн аюулгүй байдлын ач холбогдлыг сурталчилж, иргэд болон албан байгууллагуудыг өөрсдийгөө хамгаалахад уриалах
9	18-35 насны залуучууд – тэдний эцэг, эх	"Ээж, аавдаа интернэт заая"	Залуучууд нь ээж, аав, эмээ, өвөөдөө мэдэхгүйг нь зааж өгөх, гэр бүлийн эерэг харилцаа үүсгэх, анхаарал тавихад уриалах
10	Гэр хороолол, хөдөөгийн иргэд	"Өөрийн социал хаягаа өөр ямар төхөөрөмжүүд дээр нэвтэрсэн байгааг тогтмол шалгая"	Хэрхэн шалгах аргыг энгийнээр зааж өгөх, ач холбогдлыг ойлгуулах
11	35+ насны иргэд	"Одоо шинэчилье"	
Цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудлууд			
12	18+ насны иргэд	"Анхааралтай!"	Онлайн худалдаа хийхдээ баталгаатай эх үүсвэрийг ашиглах, анхаарал болгоомжтой байхад уриалах

Үндэсний медиа хэрэглээний судалгаанаас харахад иргэдэд мэдлэг, мэдээлэл түгээх контентыг бүтээхдээ нас насны онцлогт тохируулан ажиллавал илүү үр дүнтэй байна.

18-24 насныхан хошин хөгжилтэй, дуу хөгжим хосолсон, зөвлөгөө мэдээлэл өгсөн контентод дуртай байдаг бол 25-45 насны залуучууд зөвлөгөө мэдээлэл өгсөн, хошин хөгжилтэй, амьдралын бодит байдлыг харуулсан, урам зориг өгсөн контентыг илүүд үзэж байна. Харин 45-аас дээш насны хүмүүст эрүүл мэндийн агуулгатай, зөвлөгөө мэдээлэл өгсөн контент илүү таалагдах болно.

Зураг 19: Таалагдах контентын төрөл, насны бүлгээр

18-24		25-34		45-64	
#1 Хошин, хөгжилтэй	178K	#1 Зөвлөгөө мэдээлэл өгсөн	407K	#1 Зөвлөгөө мэдээлэл өгсөн	231K
#2 Дуу, хөгжим хосолсон	121K	#2 Хошин, хөгжилтэй	400K	#2 Эрүүл мэндийн агуулгатай	168K
#3 Зөвлөгөө, мэдээлэл өгсөн	119K	#3 Амьдралын бодит нөхцөл байдлыг харуулсан	234K	#3 Амьдралын бодит нөхцөл байдлыг харуулсан	156K
#4 Сонирхол татсан үг хэллэг ашигласан	98K	#4 Урам зориг өгсөн	209K	#4 Хошин, хөгжилтэй	144K
#5 Урам зориг өгсөн	74K	#5 Эрүүл мэндийн агуулгатай	206K	#5 Дуу, хөгжим хосолсон	100K
#6 Спортын агуулгатай	71K	#6 Дуу, хөгжим хосолсон	201K	#6 Гэр бүлийн агуулгатай	98K
#7 Анимейшн/ хүүхэлдэйн хэлбэртэй	70K	#7 Сонирхол татсан үг хэллэг ашигласан	196K	#7 Урам зориг өгсөн	96K
#8 Өвөрмөц, содон өнгө дизайн, график ашигласан	64K	#8 Гэр бүлийн агуулгатай	191K	#8 Хүүхдэд чиглэсэн/тоглуулсан	84K
#9 Амьдралын бодит нөхцөл байдлыг харуулсан	60K	#9 Эрч хүчийг мэдрүүлсэн	142K	#9 Эрч хүчийг мэдрүүлсэн	75K
#10 Эрч хүчийг мэдрүүлсэн	50K	#10 Хүүхдэд чиглэсэн/тоглуулсан	131K	#10 Олны танил, нэр алдартай хүн тоглосон	67K

Эх үүсвэр: Үндэсний медиа хэрэглээний судалгаа – 2021



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4



I ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын иргэдийн интернэт хэрэглээ дэлхийн дунджийг давж, өдөр ирэх тусам улам нэмэгдэж байна. Сүүлийн 10 жилд иргэдийн интернэт хэрэглээ 34%-аар өсөөд байна. Энэ цаг үед интернэтийг зохистой хэрэглэх, мэдээллийн технологийн аюулгүй байдлаа ханган интернэтийг хэрэглэдэг иргэдтэй байх нь нэн чухал юм. Энэхүү судалгаагаар Монгол Улсад анх удаа хийгдэж байгаа иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт, хандлага, туршлагыг тодруулах, цахим гэмт хэргийн талаарх ойлголт, цахим гэмт хэрэгт өртөж буй байдлыг тандан судаллаа.

Иргэдийн 85.2% нь иргэд сошиал орчинд соёлтой байж чаддаггүй гэдэгтэй санал нийлж байгаа бөгөөд 10 хүн тутмын 9 нь эцэг эхчүүд хүүхдүүдээсээ илүү сошиал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал болж байна гэж үзэж байна. Иргэдийн 87.5% нь цахим орчинд өөрийгөө хамгаалахын тулд хийж болох ядаж нэг үйлдлийг мэдэж байгаагаас нууц үгээ тогтмол солих аргыг хамгийн сайн мэдэж байна.

Иргэдийн насны бүлэг нэмэгдэх тусам эсвэл боловсролын түвшин буурах тусам мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийн түвшин буурч байна. 10 хүн тутмын 6 нь Public/private тохиргооны ялгааг мэдэхгүй, өөрийн хаягаа ямар ямар төхөөрөмж дээр нэвтэрсэн байгааг мэдэхгүй байна. Залуучуудын интернэтийн ашиглах технологийн талаарх ойлголт мэдлэг сайн байгаа бол нас ахих тусам иргэд ямар ч ойлголтгүй болж байна.

Өөрийн цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавихыг 85% нь хичээдэг хэдий ч ердөө 15% нь тогтмол тодорхой хэмжээгээр цахим хэрэглээндээ хязгаар тавьдаг байна. Интернэт, сошиал, гар утасны хэт их хэрэглээ маш их байгаа нь хоол идэж байхдаа интернэт ашигладаг байдал, болон өглөө босоод л шууд сошиал хаягаа шалгадаг байдал 49% дээш байгаагаас харагдаж байна. Мөн уг хэт их хэрэглээнээс үүдэн нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал 10 хүн тутмын 8-д нь тулгамдаж байсан байна.

Цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудал дээр иргэдийн хувьд 560 мянган хүн сошиал орчинд байршуулсан өөрийн болон ойр зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авч байсан байна. 5 хүн тутмын 1 нь сошиал медиа, имэйл хаягаа ямар нэгэн байдлаар өөрөө болон бусдыг хакердуулж байсан тохиолдол өөрт нь болон ойр дотны нэгэнд нь тулгарч байсан байна. Өөрийг нь айлган сүрдүүлсэн, занал хийлсэн утга бүхий зурвас танихгүй хүнээс авч байсан тохиолдол нийт иргэдийн 17 хувь нь тохиолдож байсан байна.

Цахим гэмт хэргийн хувьд 18-24 насныхан илүү өртсөн хандлага өндөр байна. Ялангуяа сошиал орчинд оруулсан мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авах, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас хүлээж авч байсан байдал зэрэг үзүүлэлт дээр илүү өрсөн хандлага өндөр байна. 18-34 насны залуусын 19% нь өөрөө болон ойр дотны хэн нэгэн нь онлайн худалдааны луйварт өртөж хохирч байсан байна.

Хэрэв цахим гэмт хэрэгт өрвөл 84% цагдаагийн байгууллагад хандана гэсэн боловч өөрт нь болон ойр дотны хэн нэгэн нь цахим гэмт хэрэгт өртсөн үед ердөө 34% нь цагдаад хандсан байна.

Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг харьцангуй сайн, хандлага зөв байгаа боловч өдөр тутамдаа интернэтийг зохистой хэрэглэж чадахгүй байгаа тул интернэтийг зохистой хэрэглэхийг уриалах нь зүйтэй байна.

18-24 насны иргэдийн хувьд интернэтийн хэрэглээ маш их, интернэт орчинд доромжлуулах, бусдаас сөрөг хариу үйлдэл авах хандлага өндөр байгаа нь ажиглагдсан тул цахим орчны хэрэглээгээ хянах, цахим гэмт хэрэгт өртсөн үед юу хийх хэрэгтэйг нь тодорхой зааж өгөх шаардлагатай.

25-45 хүртэлх насны иргэдийн хувьд интернэтийн хэрэглээ ажил, амьдралын өдөр тутмын хэрэглээ болсон байгаа тул хэрхэн интернэтийн хэрэглээгээ зүй зохистой байлгах, цахим гэмт хэргээс өөрийгөө болон бусад гэр бүлийн гишүүдээ хэрхэн хамгаалах ойлголтыг нэмэгдүүлж, хамгаалах технологийн шийдлүүдийг тогтмол хэрэглэхэд уриалах нь зүйтэй.

45-аас дээш насны иргэд болон хөдөөгийн иргэдийн хувьд интернэтийг хэрэглэх анхан шатны мэдлэг ойлголт бага, цахим орчин эрсдэлтэй байж болохыг сайн мэдэхгүй байгаа тул анхан шатны өөрийгөө хамгаалах технологийн шийдлүүдийг зааж өгөх, эрсдэлийн талаар ойлгуулах хэрэгтэй.

Мэдээллийг хүргэхдээ нэгдсэн цогц байдлаар нас, насны онцлогт тохируулан мэдээллийн суваг, хэлбэрийг сонгох нь зүйтэй. Иргэд ихэвчлэн видео, телевизийн контент хэлбэрээр орон даяар цацагддаг телевиз, мэдээ мэдээллийн вэбсайт, цагдаагийн байгууллагаас мэдээлэл авахыг хүсэж байна. Агуулгын хувьд мөн адил насны онцлогт тохируулан, яг хэрхэн яаж өөрийгөө болон гэр бүлээ хамгаалж, интернэтийг зохистой хэрэглэх вэ гэдгийг зааж зөвлөсөн байвал зохино. Мэдээлэл сурталчилгаагаа хүргэхдээ төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, сошиал медиа платформуудтай хамтран ажиллавал илүү үр дүнтэй байх магадлалтай.



Mongolian Marketing
Consulting Group

YOUR RESEARCH PARTNER

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХАВСРАЛТ



I ХАВСРАЛТ

Иргэдийн тоон судалгааны асуулга

ИНТЕРНЭТИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА” - 2021

Сайн байна уу? Намайг “.....” (нэрээ хэлнэ) гэдэг. Би ММCG (“Эм Эм Си Жи”) судалгааны байгууллагаас явж байна. Бид Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг, хандлага, зан үйлийн талаар суурь судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж байна.

Уг судалгаа нь иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулах юм. Энэхүү судалгаа нь Улаанбаатар хот болон 6 аймагт явагдаж байна.

Ярилцлага маань ойролцоогоор 20 минут үргэлжлэх бөгөөд таны хэлж буй саналд зөв болон буруу хариулт гэж байхгүй. Бид таны мэдээллийн нууцлалыг ЭЗОМАР, ISO 20252:2019 стандартын дагуу чандлан хадгалах бөгөөд таны өгсөн мэдээллийг зөвхөн судалгааны нэгдсэн дүгнэлт гаргах, статистикийн тоон шинжилгээнд судалгааны баг ашиглах болно. Та судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцоно. Та судалгаанд оролцохыг зөвшөөрч байна уу?

(Судалгаанд оролцогчийн зөвшөөрч байгаа нь заавал аудио бичлэгт үлдсэн байх)

Таны санаа бодол манай судалгааны үр дүнд тун чухал, үнэ цэнтэй байх болно.

	Нэр	Код
Аймаг, нийслэл:		
Сум, дүүрэг:		
Ярилцлага авагчийн нэр/код:		

Асуулга авсан:

Өдөр/сар/он					
Эхэлсэн цаг		:			
Дууссан цаг		:			

№	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ				
I. ШҮҮЛТҮҮР							
1.1	Та хэдэн настай вэ? /бичгээр бичсэний дараа тохирох хариултыг дугуйлна/ <table border="1" style="margin: 10px auto; width: 150px; height: 20px;"><tr><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr></table> ТӨРСӨН ОН					18 хүртэлх	0
		18-29	1				
		25-34	2				
		35-44	3				
		45-54	4				
55-64	5						
	65+	6					
1.2	Хүйс? (судалгаанд оролцогчоос асуухгүй)	Эрэгтэй	1				
		Эмэгтэй	2				

	АСУУЛТ	ХАРИУЛТ	ЗААВАР	
II. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ				
2.1	Та дараах төхөөрөмжүүдийн алинаар нь интернэтэд ордог бэ?	Ширээний компьютер	1	Олон сонголттой
		Нөүтбүүк (нетбүүк багтана)	2	
		Гар утсаар	3	
		Таблетаар (жш. Ipad)	4	
		Смарт зурагтаар /smart TV	5	
		Бусад /Тодруулна уу...../	90	
		Ерөөсөө ордоггүй	99	СУДАЛГААГ ДУУСГАХ
2.2	Та ямар зорилгоор интернэтийг ашигладаг вэ?	Имэйл бичих/шалгах	1	Олон сонголттой
		Facebook ашиглах	2	
		Twitter, youtube зэрэг бусад сошиал медиа ашиглах	3	
		Мессенжердэх /Чатлах /Facebook messenger, Wechat, Skype г.м/	4	
		Мэдээ, мэдээлэл авах	5	
		Google-ээс өөрт хэрэгцээтэй мэдээллийг хайх	6	
		Ажил хийх	7	
		Сурах	8	
		Интернэтээр тоглоом тоглох	9	
		Видео бичлэг үзэх (дуу, клип, бусад бичлэг гэх мэт)	10	
		Кино үзэх	11	
		Телевизийн нэвтрүүлэг үзэх	12	
		Дуу хөгжим сонсох	13	
		Подкаст (Podcast) сонсох	14	
		ФМ радио сонсох	15	
		Төлбөр тооцоо хийх, шилжүүлэг хийх	16	
		Бараа, бүтээгдэхүүн худалдан авах	17	
		Зар харах, байршуулах	18	
		Е-баримт бүртгүүлэх	19	
Төрийн үйлчилгээ авах	20			
Бусад /Тодруулна уу...../	90			
2.3	Та дараах зорилгоор өдөрт хэдэн цагийг интернэт орчинд өнгөрүүлдэг вэ?	Ажил, сургууль, хичээлээ хийх зэрэг зорилгоор	1	Тус тусад нь асуух:цагминут
		Сошиал медиа ашиглах зорилгоор	2	
		Дуу, видео үзэх зэрэг энтертаймент зорилгоор	3	
		Бараа, бүтээгдэхүүн худалдан авах зорилгоор	4	
		Мэдээ мэдээлэл хайх, авах зорилгоор	5	
		Төрийн үйлчилгээ авах зорилгоор	6	
Бусад зорилгоор /тодруулах...../	90			
2.4	Та интернэтэд ихэвчлэн яаж ордог вэ?	Өөрийн гар утасны мобайл дата ашиглаж	1	Олон сонголттой
		Өөрийн болон найз нөхөд, хамаатны гэрийн Wi-Fi -р	2	
		Гэрт LAN (кабелаар холбогдож)	3	
		Ажил/сургуулийн Wi-Fi -р	4	
		Ажил/сургууль дээр LAN (кабелаар холбогдож)	5	
		Бусад байгууллагын үнэгүй Wi-Fi	6	

		Бусад газраас /Тодруулна уу...../	90	
2.5	Таны интернэт ордог төхөөрөмжид вирусийн хамгаалалтын программ, хатуу диск инкрипт, галт хана зэргийн аль нэг нь байдаг уу?	Тийм, бүх төхөөрөмж хамгаалагдсан	1	Нэг сонголттой
		Тийм, зарим төхөөрөмж хамгаалагдсан	2	
		Үгүй	0	
		Мэдэхгүй	99	
2.5.1	[2.5 асуултад 1 эсвэл 2 гэж хариулбал асуух] Таны ямар ямар төхөөрөмж хамгаалагдсан бэ?	Ширээний компьютер	1	Олон сонголттой
		Нөүтбүүк (нетбүүк багтана)	2	
		Гар утас	3	
		Таблет (жш. Ipad)	4	
		Смарт зурагт /smart TV	5	
		Бусад /Тодруулна уу...../	90	
		Хариулахаас татгалзсан	98	
2.5.2	[2.5 асуултад 0 эсвэл 2 гэж хариулбал асуух] Таны ямар ямар төхөөрөмж хамгаалагдаагүй бэ?	Ширээний компьютер	1	Олон сонголттой
		Нөүтбүүк (нетбүүк багтана)	2	
		Гар утас	3	
		Таблет (жш. Ipad)	4	
		Смарт зурагт /smart TV	5	
		Бусад /Тодруулна уу...../	99	
		Хариулахаас татгалзсан	98	
2.5.3	[2.5 асуултад 0 эсвэл 2 гэж хариулбал асуух] Яагаад хамгаалагдаагүй вэ?		Бичих

III. ИРГЭДИЙН МЭДЛЭГ

Та дараах өгүүлбэрүүдтэй санал нийлэх үү?

	Үзүүлэлт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
3.1	Хуучин загварын төхөөрөмж (гар утас, компьютер, нөүтбүүк, таблет гм) ашиглах нь аюулгүй юу?	1	0	99
3.2	Зураг, дуу, бичлэг үзэх зэрэгт ямархуу хэмжээний дата ашигладаг болохыг та мэдэх үү?	1	0	99
3.3	Өөрийн социал хаягаа өөр ямар төхөөрөмжүүд дээр нэвтэрсэн байгааг шалгаж мэдэх үү?	1	0	99
3.4	Фейсбүүк, инстаграм зэрэг социал орчинд пост оруулахдаа Паблик/Прайвит (Public/Private) тохиргооны ялгааг мэдэх үү?	1	0	99
3.5	Фэйсбүүкийн профайл дахь зураг, нас, хүйс нь хуурамч байж болох уу?	1	0	99
3.6	Онлайнаар төрөл бүрийн сонжоо, таавар, азаа үзэх зэрэг нь аюултай юу?	1	0	99
3.7	Монгол Улсад порно сайт, зохиогчийн эрхийн зөрчилтэй сайтуудыг хаадаг гэдгийг мэдэх үү?	1	0	99
3.8	Төлбөртэй тоглоом, программыг албан бус эх сурвалжаас (Playstore, Appstore, Windows зэргээс бусад эх үүсвэр) үнэгүй татаж болдог үү?	1	0	99

3.9	Гар утас, нөүтбүүк, суурийн компьютерын программыг агдэйт (update) хийж шинэчилж болдог уу?	1	0	99
3.10	Сошиал хаяг болон банкны нууц үг ижил байж болох уу?	1	0	99
3.11	Үл таних хүнээс ирсэн линк, холбоосыг нээж үзэж болох уу?	1	0	99

IV. ИРГЭДИЙН ХАНДЛАГА

Та дараах өгүүлбэрүүдтэй хэр зэрэг санал нийлж байна вэ? 1-5 оноогоор санал нийлж буй эсэхээ илэрхийлнэ үү. 1-огт санал нийлэхгүй, 5-маш их санал нийлж байна гэсэн утгатай.

№	Үзүүлэлт	Огт санал нийлэхгүй	Бага зэрэг санал нийлж байна	Зарим талаар санал нийлж байна	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна
4.1	Зохиогчийн эрх, интернэтийн зохисгүй хэрэглээг зохицуулах хуулийн нарийн зохицуулалт шаардлагатай байна.	1	2	3	4	5
4.2	ХХЗХ-с +18 сайт болон оюуны өмчийн зөрчилтэй кино сайтад хязгаарлалт хийсэн нь зөв.	1	2	3	4	5
4.3	Эцэг эхчүүд цахим орчныг хүүхдүүд зөв зохистой хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавьж чаддаг.	1	2	3	4	5
4.4	Хүүхдийнхээ интернэт хэрэглээнд хяналт тавих нь эцэг эхчүүдийн үүрэг.	1	2	3	4	5
4.5	Эцэг, эхчүүд нь хүүхдүүдээсээ илүү сошиал медиа ашиглаж байгаа нь буруу үлгэр дуурайлал болж байна.	1	2	3	4	5
4.6	Цахим орчинд нууц үг үүсгэхдээ аль болох өөрт эргэн санахад хялбар зөвхөн тоо эсвэл тэмдэгт ашиглах нь амар.	1	2	3	4	5
4.7	Сонирхолтой мэдээлэл байвал ямар сайт байх нь хамаагүй шууд үзвэл таатай.	1	2	3	4	5
4.8	Төлбөртэй программ хангамжуудыг үнэгүй ашиглах боломж байхад заавал худалдаж авах шаардлагагүй.	1	2	3	4	5

4.9	Гар утас, нөүтбүүк, суурийн компьютерын апдэйт (update) шинэчлэлийг аль болох хийхийг хичээдэг.	1	2	3	4	5
4.10	Сошиал орчинд бусад хүмүүс ихэвчлэн сөрөг мэдээллийг хуваалцдаг.	1	2	3	4	5
4.11	Иргэд сошиал орчинд соёлтой байж чаддаггүй.	1	2	3	4	5

V. ИРГЭДИЙН ТУРШЛАГА, ЗАН ҮЙЛ

Та дараах үйлдлүүдийг хэр их давтамжтайгаар хийдэг бэ? Огт хийж байгаагүй, эсвэл хааяа, заримдаа, ихэвчлэн эсвэл үргэлж хийдэг үү?

№	Үзүүлэлт	Огт үгүй	Хааяа	Заримдаа	Ихэвчлэн	Үргэлж
5.1	Гар утас, бусад төхөөрөмжийн хэт их хэрэглээнээс болоод нүд улайх, нойргүйдэх зэрэг асуудал тулгардаг.	1	2	3	4	5
5.2	Интернэт орчинд байгаа мэдээлэл хуурамч эсэхийг, мэдээллийн эх үүсвэрийг шалгаж үздэг.	1	2	3	4	5
5.3	Төлбөртэй программ, тоглоомыг интернэтээс үнэгүй татаж авч ашиглаж байсан.	1	2	3	4	5
5.4	Гар утас, нөүтбүүк, суурин компьютерын программаа апдэйт (update) хийж шинэчилдэг.	1	2	3	4	5
5.5	Кино, драма зэрэг зохиогчийн эрхтэй контентыг интернэтээр үнэгүй үздэг.	1	2	3	4	5
5.6	Өглөө босоод шууд сошиал хаягаа хамгийн түрүүнд шалгадаг.	1	2	3	4	5
5.7	Хоол идэж байхдаа интернэт ашигладаг.	1	2	3	4	5
5.8	Өөрийнхөө цахим орчны хэрэглээнд хязгаарлалт тавьдаг.	1	2	3	4	5
5.9	Цахим хаягийн нууц үгнүүдээ 6 сар тутам сольдог.	1	2	3	4	5
5.10	Сошиал хаяг болон санхүүгийн төлбөр тооцоо хийдэг апп-уудын (банкны апп зэрэг) нууц үг өөр өөр байдаг.	1	2	3	4	5
5.11	Компьютер вирустснээс болоод зураг, материал,	1	2	3	4	5

	бусад дата мэдээллээ алдсан.								
VI. ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТСӨН БАЙДАЛ									
6.1	Таны бодлоор хувийн мэдээлэл гэж юу вэ?	Нэр	1	<i>Олон сонголттой (хариултыг уншиж өгөхгүй)</i>					
		Утасны дугаар	2						
		Имэйл хаяг	3						
		Ажилладаг байгууллага	4						
		Гэрийн хаяг	5						
		Регистрийн дугаар	6						
		Бусад /Тодруулна уу...../	90						
		Мэдэхгүй	99						
6.2	Хувийн мэдээллээ интернэт орчинд алдсанаар ямар эрсдэлүүд учирч болох вэ?		<i>Бичих</i>					
				ОГТ ҮГҮЙ	Хааяа	Заримдаа	Ихэвчлэн	Үргэлж	Хариулахаас татгалзсан
6.3	Таны ойр дотнын хэн нэгэнд дараах зүйлс хэр давтамжтайгаар тохиолдож байсан бэ?	6.3.1 Таньдаг хүнээс ирсэн линк дээр дарсны улмаас банкны КАПТаасаа өөрийн мэдэлгүй мөнгө суутгуулж хохирч байсан	1	2	3	4	5	98	
		6.3.2 Сошиал орчинд байршуулсан зураг, мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл (зүй бус бүдүүлэг үг хэллэгээр доромжлуулах) авч байсан	1	2	3	4	5	98	
		6.3.3 Айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зүйл үл таних хүнээс чат, мессежээр хүлээн авч байсан	1	2	3	4	5	98	
		6.3.4 Хувийн зураг, бичлэгээ алдаж, олон нийтэд тараалгуулж байсан	1	2	3	4	5	98	
		6.3.5 Онлайн орчинд гүтгэн, гутаан доромжилж, хуурамч мэдээлэл пост тавих замаар нэр хүндэд халдсан	1	2	3	4	5	98	
		6.3.6 Интернэт, нийгмийн сүлжээгээр эсрэг хүйсийн хүнээс +18 агуулгатай зураг, бичлэг хүлээн авч, садар самуунд уруу татахыг оролдож байсан	1	2	3	4	5	98	
		6.3.7 Онлайн худалдааны луйварт өртсөн	1	2	3	4	5	98	
		6.3.8 Хэрвээ нүцгэн зураг, хувийн мэдээллээ явуулбал мөнгө өгье гэсэн агуулгатай мессеж, чат ирж байсан	1	2	3	4	5	98	
		6.3.9 Онлайн орчинд миний нэрийг ашиглан өөр хүн хуурамч аккоунт	1	2	3	4	5	98	

		үүсгэж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж байсан						
		6.3.10 Онлайн орчинд банкны КАПтын залиланд өртөж байсан	1	2	3	4	5	98
		6.3.11 Сошиал медиа, имэйлээ хакердуулсан	1	2	3	4	5	98
		6.3.12 Интернет, нийгмийн сүлжээгээр итгэл төрүүлэн манай найзын хувийн (+18) агуулгатай зураг бичлэгийг авч, дараа нь олон нийтэд тараана гэж сүрдүүлэн мөнгө нэхэж байсан	1	2	3	4	5	98
6.4	Дээрх төрлийн цахим гэмт хэрэгт өртвөл та хаана хандах вэ?	Цагдаагийн байгууллагад	1	<i>Олон сонголттой (Хариултыг уншиж өгөхгүй)</i>				
		Найз нөхдөдөө	2					
		Интернэтээс мэдээлэл хайна	3					
		Бусад /тодруулах/	90					
		Хаана ч хандахгүй	0					
		Мэдэхгүй	99					
6.5	[6.3.1, 6.3.5, 6.3.6, 6.3.7, 6.3.8, 6.3.9, 6.3.10, 6.3.12 асуултуудад 2-5 гэж хариулбал асуух] Та эсвэл таны эргэн тойрны хүн тэр үед юу хийсэн бэ?	Цагдаагийн байгууллагад мэдээлсэн	1	<i>Олон сонголттой (Хариултыг уншиж өгөхгүй)</i>				
		Цагдаагийн байгууллагад мэдээлээгүй	2					
		Вирусийн хамгаалалтын программ суулгасан эсвэл шинэчилсэн	3					
		Тухайн этгээдийг блок хийсэн	4					
		Найз нөхдөөсөө зөвлөгөө авсан	5					
		Юу ч хийгээгүй	0					
		Бусад /тодруулах...../	90					
		Юу хийхээ мэдээгүй	99					
		Хариулахаас татгалзсан	98					
6.6	[Асуулт 6.5-т 2,0 гэж хариулсан бол] Яагаад?	<i>Бичих</i>					

	АСУУЛТ	ХАРИУЛТ	ЗААВАР
VII. МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ			
7.1	Та тоон гарын үсэг гэж сонсож байсан уу?	Тийм	1
		Үгүй	0
7.2	Таны бодлоор тоон гарын үсэг гэж юу вэ?	<i>Бичих</i>
7.3	Цахим орчинд өөрийгөө хамгаалах үүднээс ямар үйлдлийг хийх нь зөв гэж бодож байна вэ?	Цахим хаягийн нууц үгээ тогтмол солих	1
		Танихгүй хүмүүстэй найз болохгүй байх	2
		Бусдын нэр төрд халдсан пост бичихгүй, шэйрлэхгүй байх	3
		Үнэн эсэх нь тодорхойгүй мэдээлэл авч цааш түгээхгүй байх	4
		Нэр төрд халдсан, гүтгэн доромжилсон пост, мессеж зэргийг цагдаад мэдэгдэх	5
		Зүй бус бичлэг, порнограф, хүчирхийлэл, хар тамхи, архидан согтуурах агуулгатай видео, аудио, зурагт хуудас үзэхгүй, тараахгүй байх	6

		Өөрийн чинь нэр төрд халдсан, гүтгэсэн пост, мессежийг блоклох	7							
		Бусад /Тодруулна уу...../	8							
			ОГТ ҮГҮЙ	Хааяа	Заримдаа	Ихэвчлэн	Үргэлж	Хариулахаас татгалзсан		
7.4	Таны ойр дотнын хүмүүс дараах үйлдлүүдийг хэр давтамжтайгаар хийдэг вэ?	7.4.1 Гар утас, таблет, компьютер зэрэг хувийн төхөөрөмждөө нууц үгний хамгаалалт хийдэг	1	2	3	4	5	98		
		7.4.2 Олон нийтийн болон үйлчилгээний газрын Wifi сүлжээнд холбогддог	1	2	3	4	5	98		
		7.4.3 Хувийн төхөөрөмждөө (гар утас, таблет, пад) хэт хувийн шинж чанартай өөрийн болон бусдын зураг, дансны нууц код гэх мэтийг хадгалдаг	1	2	3	4	5	98		
		7.4.4 Хувийн мэдээлэлтэй төхөөрөмжөө бусдад гар дамжуулан ашигладаг	1	2	3	4	5	98		
		7.4.5 Нийтийн компьютерт холбогдсоны дараа цахим хуудаснаасаа Log out/Sign out хийдэг	1	2	3	4	5	98	0	
		0- Нийтийн компьютерт холбогдож байгаагүй								
		7.4.6 Зургаа хадгалах зорилгоор олон нийтийн сүлжээнд байршуулдаг	1	2	3	4	5	98		
		7.4.7 Олон нийтийн сүлжээний хэрэглэгчээс санал болгосон программ хангамжийг шууд татан авдаг	1	2	3	4	5	98	0	
		0- Олон нийтийн сүлжээний хэрэглэгчээс программ хангамж санал болгож байгаагүй								
7.5	Цахим сүлжээнд олон цагийг зарцуулснаас болж танд дараах эрүүл мэндийн эрсдэлүүдийн аль нь бий болно гэж бодож байна вэ? (Хамгийн эрсдэлтэй 5-г сонгуулах)	7.4.8 Бусдын гар утас, таблет, компьютерыг ашиглахдаа хувийн мэдээллээ ашигладаг	1	2	3	4	5	98	0	
		0- Бусдын гар утас, таблет, компьютерыг ашиглаж байгаагүй								
		Нүдний хараа муудах	1	Олон сонголттой						
		Ядаргаанд орох	2							
		Нуруу нугасны зөв бус хөгжилтэй болох	3							
		Гар утас, компьютер зэрэг дэлгэцэд донтох	4							
		Сэтгэл санааны байдал тавгүй, сэтгэлээр унах, өөртөө итгэлгүй болох, аймхай болох	5							
Дархлаа муудах	6									
Уур уцаартай болох	7									

		Зожиг болох	8	
		Ажилдаа сонирхолгүй болох	9	
		Гэр бүлийнхэнтэйгээ харилцаа муудах	10	
		Хоолонд муу болох	11	
		Бусад /Тодруулна уу...../	12	
7.6	Ekids.mn, happywebs.mn зэрэг цахим орчны ёс зүйтэй хэрэглээг сурталчлан таниулах, цахим орчинд хэрхэн хамгаалах, нийгмийн сүлжээний эерэг болон сөрөг үр дагаврын талаарх нийтлэлүүдийг уншиж байсан уу?	Тийм	1	<i>Нэг сонголттой</i>
		Үгүй	2	
7.7	Та интернэтийн зохистой хэрэглээ, хор хөнөөл, хэрхэн өөрийгөө болон бусдыг цахим орчны гэмт хэрэг, дарамт шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг хаанаас авахыг хүсэж байна вэ? (Эхний 5 хувилбарыг сонгуулах)	Сум, дүүргийн ФБ хуудаснаас	1	<i>Олон сонголттой</i>
		Баг, хорооны иргэдийн ФБ группээс	2	
		e-mongolia цахим хуудаснаас	3	
		Ном сэтгүүл, хэвлэмэл материалаас	4	
		Цахим мэдээ, мэдээллийн вэбсайтаас (gogo.mn, ikon.mn гэх мэт)	5	
		Тусгайлсан вэбсайтаас	6	
		Найз нөхдөөсөө	7	
		Орон даяар цацагддаг телевизээс	8	
		Орон нутгийн телевизээс	9	
		Фм, радиогоос	10	
		Сум, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан	11	
		Сум, дүүргийн ЗДТГ-ын мэдээллийн самбараас	12	
		Баг, хорооны байрны мэдээллийн самбараас	13	
		Иргэдийн нийтийн хурлаас	14	
		Цагдаагийн байгууллагаас	15	
		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас (Юнивишн, ДДИШ, Скаймедиа гэх мэт интернэтээ авдаг газруудаас)	16	
		Мэдээлэл авахыг хүсэхгүй байна	0	
		Мэдэхгүй /Уншиж өгөхгүй/	99	
		Хариулахаас татгалзсан /Уншиж өгөхгүй/	98	
7.8	Та энэ төрлийн мэдээллийг ямар хэлбэрээр авахыг хүсэж байна вэ? (Эхний 3 хувилбарыг сонгуулах)	Видео хэлбэрээр	1	<i>Олон сонголттой</i>
		Ном сэтгүүл, хэвлэмэл тараах материал хэлбэрээр	2	
		Подкаст хэлбэрээр	3	
		Утсаар	4	
		Мессежээр	5	
		Телевизийн контент хэлбэрээр	6	
		ФБ постоор	7	
		ФБ сторигоор	8	

№	АСУУЛТ	ХАРИУЛТ		ЗААВАР
		ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
		Бүлгийн сургалтаар	9	
		Онлайн сургалтаар	10	
		Бусад /тодруулах/	90	
		ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
I.1	Танай өрхийн сарын дундаж орлого хэдэн төгрөг вэ?	Орлогогүй	0	<i>Нэг сонголттой</i>
		200,000 төгрөг хүртэл	1	
		200,001-420,000 төгрөг	2	
		420,001-1,000,000 төгрөг	3	
		1,000,001-1,500,000 төгрөг	4	
		1,500,001-2,000,000 төгрөг	5	
		2,000,001-2,500,000 төгрөг	6	
		2,500,001-3,000,000 төгрөг	7	
		3,000,001-3,500,000 төгрөг	8	
		3,500,001-4,000,000 төгрөг	9	
		4,000,001-4,500,000 төгрөг	10	
		4,500,001-5,000,000 төгрөг	11	
		5,000,001 төгрөг болон түүнээс дээш	12	
		Мэдэхгүй /уншиж өгөхгүй/	98	
		Хариулахаас татгалзсан /уншиж өгөхгүй/	99	
I.2	Таны боловсролын түвшин? <i>(Судалгаанд оролцогчийн одоогийн эзэмшсэн боловсролын түвшнийг тэмдэглэнэ. Хэрэв одоо их, дээд сургуульд сурдаг бол бүрэн дунд эсвэл тусгай дунд боловсролтой гэж үзнэ.)</i>	Дээд боловсролтой	1	<i>Нэг сонголттой</i>
		Тусгай дунд боловсролтой /МСҮТ, Коллеж төгссөн/	2	
		Бүрэн дунд боловсролтой /10-12 анги төгссөн/	3	
		Бүрэн бус дунд боловсролтой, суурь боловсролтой /8-9 анги төгссөн/	4	
		Бага боловсролтой /4-5 анги төгссөн/	5	
		Боловсрол эзэмшээгүй	6	
		Хариулахаас татгалзсан /уншиж өгөхгүй/	99	
I.3	Таны амьдардаг сууцны төрөл?	Орон сууц	1	<i>Нэг сонголттой</i>
		Хашаа байшин	2	
		Монгол гэр	3	
		Хаус	4	
		Орон сууцны хажуу өрөө	5	
		Сургуулийн дотуур байр	6	
		Оюутны дотуур байр	7	
		Нийтийн байр	8	
		Бусад /Тодруулна уу...../	9	
I.4	Таны ажил эрхлэлтийн байдал	Төрийн болон төсвийн байгууллага	1	<i>Нэг сонголттой</i>
		Олон улсын байгууллага	2	
		Төрийн бус байгууллага /ТББ/	3	
		Хувийн байгууллага	4	
		Хувиараа бизнес эрхлэгч болон өрхийн бизнес эрхлэгч	5	

		Оюутан	6											
		ЕБС-ийн сурагч	7											
		Тэтгэвэрт	8											
		Группт	9											
		Малчин	10											
		Ажил эрхлэхгүй байгаа /уншиж өгөхгүй/	0											
		Бусад /Тодруулна уу...../	90											
		Хариулахаас татгалзсан /уншиж өгөхгүй/	99											
I.5	Судалгаанд оролцогчийн гар утасны дугаар:	Утас 1	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr></table>											
		Утас 2	<table border="1"><tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr></table>											
I.6	Таны нэр хэн бэ? (Судалгаанд оролцогчийн зөвхөн нэрийг эхний үсгийг томоор, галиглахгүй кириллээр бичнэ. Монгол хэлний дүрмийн дагуу нэрийг бичнэ үү Жишээ нь "Бат-Эрдэнэ, Дашдорж" гэх байдлаар)		Бичих										

БИДНИЙ СУДАЛГААНД ОРОЛЦСОНД ТАНД БАЯРЛАЛАА

Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нарын гүнзгийрүүлсэн ярилцлагын удирдамж

“ИНТЕРНЭТИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУУРЬ СУДАЛГАА” - 2021

Бид Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг, хандлага, зан үйлийн талаар суурь судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулж байна.

Уг судалгаа нь иргэдийн интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулах юм. Суурь судалгааны хүрээнд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын байр суурийг сонсох, санаа бодлыг тодруулах зорилгоор энэ ярилцлагыг хийж байна.

Ярилцлага маань ойролцоогоор 40 минут үргэлжлэх бөгөөд таны хэлж буй саналд зөв болон буруу хариулт гэж байхгүй. Бид таны мэдээллийн нууцлалыг ЭЗОМАР, ISO 20252:2019 стандарт, Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу чандлан хадгалах бөгөөд зөвхөн судалгааны нэгдсэн дүгнэлт гаргах, статистикийн тоон шинжилгээнд судалгааны баг ашиглах болно. Та судалгаанд сайн дурын үндсэн дээр оролцоно. Та бүхний санаа бодол манай судалгааны үр дүнд тун чухал, үнэ цэнтэй байх болно.

1. Та өөрийн ажилладаг компани, үйл ажиллагааныхаа талаар танилцуулна уу.
2. Интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангахад танай компанийн зүгээс ямар ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан бэ? Тэр нь хэр зэрэг үр дүнтэй болж байсан бэ? Энэ талаар ажиллах төлөвлөгөө байгаа юу? Иргэдэд зориулж мэдлэг мэдээлэл хүргэдэг үү? Тийм бол ямар хэлбэрээр, хэрхэн хүргэдэг вэ?
3. Өөр ямар ямар арга хэрэгслээр иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж, интернэтийг зохистой хэрэглэж, мэдээллийн технологийн аюулгүй байдлаа хангадаг иргэдийг төлөвшүүлж болох вэ? Олон улсад ямар түршлэгүүд байдаг вэ? Монгол Улсад технологийн хувьд бид юу юу хийх боломж байна вэ? Танай компанийн хувьд ямар боломжтой вэ?
4. Эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар ямар саад бэрхшээл тулгардаг вэ? Санхүүгийн хувьд, техник технологийн хувьд, хууль тогтоомжийн хувьд ямар ямар асуудлууд байна?
5. Ямар ямар шийдлүүд байж болох вэ? Түүнд төрийн зүгээс ямар дэмжлэг байвал зохих вэ?
6. Монгол Улсын интернэт орчинтой холбоотой эрхзүйн зохицуулалт хангалттай байдаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол ямар нэмэлт зохицуулалт шаардлагатай байна вэ? Яагаад?
7. Иргэд интернэтийг зохистой хэрэглэхийн тулд юу юуг мэдэж байвал зохих вэ? Юу юуг зуршил болгон хийдэг байвал интернэтийг зохистой хэрэглэж байна гэж үзэх вэ?
8. Мэдээллийн технологийн аюулгүй байдлаа хангахын тулд иргэд юу юу мэдэж байх хэрэгтэй вэ? Юу юуг хийдэг байвал болох вэ? Иргэдийн энэ талаарх ойлголт мэдлэг, хандлага ямар байдаг вэ?
9. Танд өөр энэ асуудалтай холбоотой нэмж хэлэхийг хүссэн зүйл байна уу?

МАНАЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАНД БАЯРЛАЛАА.



**Mongolian Marketing
Consulting Group**

YOUR
RESEARCH
PARTNER



 976 77000188

 info@mmcg.mn

 www.mmcg.mn

 Mongolian Marketing Consulting Group

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Зүүн хүрээ хотхон, 203-р барилга, 4 давхарт